



АСЕМ 2016 БА МОНГОЛ УЛС

МОНГОЛ-ГЕРМАНИЙ XIII ЧУУЛГАН



Зохиогчийн эрх

**©Конрад-Аденауэр-Сан
Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар
Сөүлийн гудамж, Браухаус-22
Улаанбаатар 210628
Монгол улс**

**Орчуулсан: Золжаргал Ноёманн
Удвалын Эрдэнэсанаа**
**Хянасан: Др. Даниел Шмюкинг
Батмөнхийн Дөлгөөн**

Улаанбаатар, 2016

АГУУЛГА

4 | ӨМНӨХ ҮГ

Пунсалмаагийн Очирбат - *Монгол Улсын анхны Ерөнхийлөгч бөгөөд Монгол-Германы Чуулганы Тэргүүн*

6 | АСЕМ - ЫН ТҮҮХ БА ИРЭЭДҮЙ

Марк Хауптманн – *ХБНГУ-ын Бундестагийн гишүүн бөгөөд Эдийн засаг, эрчим хүчний хорооны гишүүн*

14 | АСЕМ - МОНГОЛ ТАЛЫН БАЙР СУУРЬ

Лувсанвандангийн Болд – *МУ-ын УИХ-ын гишүүн бөгөөд УИХ дахь Монгол-Германы Парламентын бүлгийн дарга*

19 | АСЕМ - ГЕРМАН ТАЛЫН БАЙР СУУРЬ

Манфред Грунд – *ХБНГУ-ын Бундестагийн гишүүн бөгөөд Бундестаг дахь ХАХ/ХСХНамын бүлгийн дарга*

24 | АСЕМ - ЫН ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТЫН СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Др. Доржраагийн Мөнхтөр – *Монгол улсын Стратеги Судлалын Хүрээлэнгийн Европ, Хойд Америк судлалын төвийн эрхлэгч*


30 | АСЕМ - ЫН ДЭЭД ТҮВШНИЙ 11 ДҮГЭЭР УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ЯВЦ

Лувсанцэрэнгийн Оргил - *Элчин сайд бөгөөд АСЕМ-ын Бэлтгэл Ажлын Албаны Ахлах албан тушаалтан*



ӨМНӨХ ҮГ

Та бүхэнд Монгол-Германы Чуулган ТББ-ын өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэнд дэвшүүлэхийн ялдамд тус Чуулганы ээлжит 13 дугаар бага хурлын материалыг цахим ном хэлбэрээр толилуулж байгаадаа би нэн баяртай байна.



**Монгол-Германы
Чуулганы энэ удаагийн
бага хурал Монгол,
ХБНГУ-ын ард түмний
аль алиных нь хувьд
түүхэн гэж үзэхүйц үйл
явдал тохиож буй жил
зохион
байгуулагдсанаараа
онцлог байлаа.**

Монгол-Германы Чуулганы энэ удаагийн бага хурал Монгол, ХБНГУ-ын ард түмний аль алиных нь хувьд түүхэн гэж үзэхүйц үйл явдал тохиож буй жил зохион байгуулагдсанаараа онцлог байлаа. Учир хэмээвээс, монголчууд бид анхны ардчилсан чөлөөт сонгууль явуулж, Монгол орон ардчилал, зах зээлийн харилцааны замыг зориглон сонгосноос хойш нэгэн зууны дөрөвний нэгийг ардаа орхижээ. Түүнчлэн Германы ард түмэн улс үндэснийхээ нэгдлийг дахин сэргээсний 25 жилийн ой ч энэ жил давхцаж байна.

Монгол-Германы харилцааны энэхүү түүхэн он жилүүдэд Монголын шинэ залуу ардчиллыг бойжин төлөвшихөд, ялангуяа Монгол-Германы Чуулганыг хоёр талын харилцааны нэгэн чухал суваг болж анх байгуулагдсан цагаас нь дэмжин тусалж, найрсгаар хамтран ажиллаж ирсэн ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сан, түүний удирдлагад, тус сангийн Монгол дахь товчооны үе үеийн суурин төлөөлөгч нарт энэ ялдамд гүн талархал илэрхийлэхийг хүсч байна.

Монгол-Германы Чуулганы ээлжит бага хурал бүрээр бид манай хоёр орны нийгэм, олон нийтийн анхаарлыг татсан, ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлдэг. Цаашлаад бид манай орны улс төр, нийгэм эдийн засаг, ирээдүйн хөгжлийн төлөвтэй холбоотой асуудлуудаас эхлээд олон улсын аюулгүй байдал, гадаад бодлогын хийгээд хоёр талын хамтын ажиллагааны чухал асуудлуудыг авч хэлэлцэн санал бодлоо илэн далангүй солилцож, улмаар дуу хоолойгоо Монгол, Германы нийгэм, олон нийт төдийгүй төр засгийн удирдлагын анхаарал сонорт хүргэсээр ирсэн сайхан уламжлалтай.

Энэ удаагийн бага хурлын явцад бид манай хоёр улсын оршин байгаа Ази, Европ тивийн улс гүрнүүдийг хамарсан өргөн төлөөлөл бүхий АСЕМ-ын асуудлаар санаа бодлоо солилцсон юм. Учир нь Монгол улс ирэх 2016 онд АСЕМ-ын дээд хэмжээний 11 дүгээр уулзалтыг эх орондоо зохион байгуулах нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргийг хүлээн аваад бэлтгэл ажлыг нь хангаж байгаа билээ.

Анх үүссэнээсээ хойш даруй 20 жил болж буй АСЕМ хэмээх энэхүү үйл явцын хувьд бататган бэхжүүлж, анхаарч бодууштай зүйлүүд болон цаашдын хөгжил дэвшилд учир хамааралтай санаа бодлоо хуваалцах сайхан боломж бидэнд олдсон юм. Өөрөөр хэлбэл, монголчууд бидний өмнө тавигдаад байгаа нэн чухал асуудал, өндөр хариуцлага, амаргүй зорилтуудыг оновчтой шийдвэрлэж, АСЕМ-ын тэгш ойн жилийн энэхүү уулзалтыг амжилттай зохион байгуулахад чиглэсэн бидний бодол санаа, хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт нэгэн зүгт

байж, Монгол-Германы ард түмнүүдийн цаашдын бүтээлч хамтын ажиллагаа үр шимээ өгнө гэдэгт миний бие итгэлтэй байна.

“АСЕМ 2016 ба Монгол” сэдвээр Берлин хотноо зохион байгуулагдсан ээлжит бага хурлын материалыг ийнхүү олон нийтийн хүртээл болгож байгаадаа бид нэн баяртай байна. Та энэхүү цахим номыг таалан болгооно уу.

*Монгол-Германы Чуулганы Тэргүүн,
Монгол Улсын анхны Ерөнхийлөгч
Пунсалмаагийн ОЧИРБАТ*



Улаанбаатар хот
2015.12.25

**Монгол-Германы
Чуулганы ээлжит бага
хурал бүрээр бид манай
хоёр орны нийгэм, олон
нийтийн анхаарлыг
татсан, ашиг сонирхлыг
хөндсөн асуудлуудын
хүрээнд хэлэлцүүлэг
өрнүүлдэг.**

**Энэ удаагийн бага
хурлын явцад бид манай
хоёр улсын оршин
байгаа Ази, Европ
тивийн улс гүрнүүдийг
хамарсан өргөн
төлөөлөл бүхий
АСЕМ-ын асуудлаар
санаа бодлоо солилцсон
юм.**

АСЕМ-ЫН ТҮҮХ БА ИРЭЭДҮЙ

Оршил



Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо 2016 оны 7 дугаар сард АСЕМ-ын 11 дүгээр чуулга уулзалтыг хуралдуулахаар товлосон билээ. Монгол улс түүхэндээ анх удаа энэ төрлийн өндөр дээд хэмжээний олон улсын уулзалтыг зохион байгуулах гэж байна. Үүний зэрэгцээ Европ, Азийн 53 гишүүн орны төрийн болон засгийн газрын тэргүүдийн энэхүү албан бус хэлэлцээ форум нь энэ онд 20 жилийн ойн баяраа тэмдэглэнэ. Улаанбаатарт зохиогдох чуулга уулзалтаар өмнө нь бусад чуулга уулзалтуудаар хөндөгдөж байгаагүй Европ ба Ази тив дэх олон тооны зөрчилдөөнт асуудлууд, түүнчлэн эдийн засгийн болон институци хоорондын хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар хэлэлцэнэ. Европын Холбооны орнуудад энэ нь нэн чухал ач холбогдолтой байх болно. АНУ нь 2009 оноос хойш "Pivot to the Asia-Pacific" гэх түлхүүр үгийн дор Ази тив рүү анхаарлаа улам хүчтэй хандуулах болсон. Үүний хүрээнд байгуулсан буюу байгуулахаар төлөвлөсөн олон тооны чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээр нь Ази, Америкийн эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлж байгаа ба Европын Холбооны хувьд илүү идэвхжих шаардлагатай болоод байна. Энэ үүднээс авч

Улаанбаатарт зохиогдох чуулга уулзалтаар өмнө нь бусад чуулга уулзалтуудаар хөндөгдөж байгаагүй Европ ба Ази тив дэх олон тооны зөрчилдөөнт асуудлууд, түүнчлэн эдийн засгийн болон институци хоорондын хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар хэлэлцэнэ.

үзвэл Европ болон Ази хоорондын улс төрийн харилцааны платформуудын үүрэг роль улам өсч байна. Өдгөө хүртэл тодорхой хэмжээнд дутуу үнэлэгдэж ирсэн АСЕМ нь Европ-Азийн харилцааг гүнзгийрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж болох юм. Асуудлын гол нь АСЕМ ирээдүйд одоо байгаа яриа хэлцээний платформ хэлбэрээсээ илүү өргөжин хөгжиж чадах эсэхт оршиж байна. Аливаа ойн арга хэмжээ нь өнгөрсөн хугацааны үйл явцад дүгнэлт хийх болон ирээдүйн алсын хараагаа тодорхойлох боломжийг олгодог. Үүсгэн байгуулагдсанаасаа хойш 20 жилийн нүүрийг үзэж буй АСЕМ-ыг илүү эрчимтэй институтчилэх болон хамтын ажиллагааг нь хэрхэн гүнзгийрүүлэх талаар үр дүнтэй хэлэлцэх цаг нь болсон.

Өнгөрсөн 20 жилийн үр дүн

АСЕМ-ын чуулга уулзалт нь өнгөрсөн 20 жилийн хугацаанд Евразийн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээн дэх олон талт хэлэлцээний гол форум болсон. 1996 онд Бангкок хотноо зохиогдсон анхны чуулга уулзалтад 25 орны төр, засгийн газрын тэргүүд оролцож байсан бол өдгөө уг тоо хоёр дахин нэмэгдэв. Өөр аль ч засгийн газар хоорондын байгууллага ийм олон талт төлөөллийг бүрдүүлж чадаагүй байна. АСЕМ-ын орнууд дэлхийн хүн амын 63 хувийг эзэлдэг, дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний тал хувийг үйлдвэрлэдэг ба дэлхийн худалдааны 60 хувийг бүрдүүлдэг. АСЕМ нь гишүүдийн тоогоороо ч, хамаарч буй газар нутгийн хэмжээгээрээ чөргөн хүрээг хамардаг. Энэ нүсэр хүрээ бүхий форум нь дэлхийн засаглалд болон хоёр тивийн нийтлэг асуудлуудад хэр бодит нөлөө үзүүлэх боломжтойг тодорхойлоход бэрх. Бүтцийн хувьд АСЕМ нь төдийлөн том биш юм. Уг форум нь үндсэн дэг журмын шинж чанаргүй, харин "албан бус ба зөвшилцөлд тулгуурласан ажлын хэв маягтай" бөгөөд "олон талт харилцааны сулавтар буюу заавал биелүүлэх албагүй, зөвхөн зөвлөмжийн чанартай

шийдвэр гаргадаг” бүтэцтэй. Дундад-болон Зүүн Азийн бүс нутгийн өнгөрсөн 20 жилийн хугацаан дахь хурдацтай хөгжлийг авч үзвэл институтчилсэн хамтын ажиллагааны дутагдалтай байдал нь Европын Холбооны орнуудын хувьд хангалттай биш байж болох ч, АСЕМ нь хэлэлцээний форумын хувьд бүс нутаг хоорондын солилцоонд асар их ач холбогдолтой юм. Хүчирхэг эдийн засагтай Европ тивийн улс орнуудын хүн ам зүй нь буурах чиг хандлагатай байгаа бол Ази-Номхон далайн орнууд 4,1 тэрбум хүн амаараа дэлхийн хүн амын 58 хувийг бүрдүүлж байна. Мөн Европ тив нь шинэ түүхий эд материалын холбогдолтойгоор анхаарлаа дорно зүгт чиглүүлэх шаардлагад хүрч буйг тэмдэглэх нь зүйтэй. Иймд олон талт хамтын ажиллагаа буюу олон түвшний засаглалын хүрээнд (multi-level governance) эдийн засгийн шинэ их гүрнүүдтэй байнгын харилцаатай байх нь Европын улс орнуудын үндсэн ашиг сонирхолд нийцнэ. АНУ-ын хувьд Номхон далайн ихэнх орнуудтай Номхон далайн эдийн засгийн хэлэлцээрийн (Trans-Pacific Partnership-TPP) хүрээнд ахисан түвшний хамтын ажиллагаа эрхэлдэг ба Европ тив ч мөн цаг үеэсээ хоцрохгүйн тулд Азитай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Өнөөг хүртэлх эдийн засгийн хамтын ажиллагааны болон олон улсын аюулгүй байдлын институтчилсэн бүтцийг авч үзвээс Ази, Европын хамтын ажиллагаа нь зөвхөн хоёр талт шинж чанартай байна. Мөн өнөөгийн хоёр талт чөлөөт эдийн засгийн гэрээ хэлэлцээрүүд ч дээрх шинж чанарыг нотлох бөгөөд Евразийн засгийн газрууд хоорондын интеграцийн бодлого дутагдаж байна. АСЕМ-ын институтчилэлийг гүнзгийрүүлэх нь энэхүү хоосон орон зайг нөхөх боломжийг бүрдүүлнэ. Одоогийн байдлаар АСЕМ-аас боломжит хамтын ажиллагааны эсвэл нийтлэг ашиг сонирхлын асуудлаар хамтарсан улс төрийн мэдэгдэл гаргахаас өөр илүү тодорхой үр дүн хүлээх боломжгүй байна. АСЕМ нь эдүгээ хамтарсан үйл ажиллагааны платформ гэхээсээ илүү хэлэлцээний платформ шинжтэй байна. Ийм тохиолдолд хамгийн сайндаа л нийтээрээ нэгдсэн ойлголцолд хүрэхэд, түүнчлэн улс төрийн салбарт тухайлсан түншүүд хамтарсан тодорхой үйл ажиллагаа явуулахад тус дөхөм болж чадах юм. Хүйтэн дайны дараа үүсч бий болсон олон талт форумуудын нийтлэг замналыг АСЕМ ч бас туулсан. Эхний үеийн эерэг сэтгэл догдлол нь их хүлээлт үүсгэж, дараа нь урам хугарах үе тохиож, улмаар зардал хэмнэх эрмэлзэл нь АСЕМ-ын хүрээнд ч тохиолдсон.

АСЕМ өнөөг хүртэл хоёр чухал зорилтыг биелүүлсэн. Нэгдүгээрт: гишүүнчлэл буюу оролцоог хангах асуудал. Улс орны төрийн тэргүүд тулгарч буй эн тэргүүний асуудлуудынхаа талаар АСЕМ-ын үеэр туслахууд болон ажилтнуудынхаа хүрээллээс ангид, санал бодлоо өөр хоорондоо чөлөөтэй солилцох боломж бүрдүүлдэгийг нь үнэлдэг. 53 орны төр, засгийн тэргүүд эсвэл тэдний төлөөлөгчид нь хэвлэл мэдээллийнхэн тэдний ярианы видео болон аудио бичлэгийг дараагаар нь хэсэгчлээд эсвэл засварлаад цацах вий гэх айдас, болгоомжлолгүйгээр хоорондоо тайван чөлөөтэй харилцах боломжтой байдаг нь АСЕМ-ын онцлог юм. Харин шүүмжлэгчид үүнийг өөр өнцгөөс хардаг бөгөөд АСЕМ-ыг ил тод байдалгүй гэх нь бий. Энэхүү дүрэм, тодорхой бүтэцгүй байдал нь АСЕМ-ын хэлэлцээ бодит байдал дээр биеллээ олоход бэрхшээл учруулж байна гэж тэд үздэг.

АСЕМ-ын чуулга уулзалт нь өнгөрсөн 20 жилийн хугацаанд Евразийн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд олон талт хэлэлцээний гол форум болсон.

АСЕМ-ын чуулга уулзалтын хамгийн чухал элемент нь хүн хоорондын холбоо юм.

Иймд АСЕМ-ын үеэр үзэл бодлоо албан бусаар солилцох хэлбэрийг хадгалж үлдэх хэрэгтэй ба ингэхдээ арга зүйн хувьд институтчилэлийг нь цаашид хөгжүүлэн сайжруулахуйц зохион байгуулалтыг бий болгож болно.

**АСЕМ гурван тулгуур
багана дээр тогтдог
эдгээр нь эдийн засаг,
улс төр, соёлын
салбарууд юм.**

**Ялангуяа Европын талд
АСЕМ нь Азийн эрчтэй
хөгжилд оролцох,
хамтран бүтээн
байгуулалт бий болгох
том боломжийг олгох
ЮМ.**

**Ази тивийн улс
орнуудад Европын гол
хөдөлгүүр хэмээн
үнэлэгддэг ХБНГУ нь
үлгэр жишээч байх
үүргийнхээ үүднээс
төдийгүй, Азийн бүс
нутагт эдийн засгийн,
улс төрийн, соёлын
хүчтэй ашиг
сонирхолтойгийнхоо
хувьд АСЕМ-ыг
гүнзгийрүүлэхийн төлөө
илүү хүчин чармайлт
гаргах хэрэгтэй.**

Хоёрдугаарт: албан бус уулзалтын хэлбэр. АСЕМ-ын чуулга уулзалтын хамгийн чухал элемент нь хүн хоорондын холбоо юм. Том эдийн засагтай орнууд уг чуулга уулзалтад оролцоходоо цаг болон мөнгөө хэмнэдэг бол жижиг орнуудын хувьд томоохон гүрнүүдтэй шууд харилцах боломж олддог. Ингэснээр жишээ нь Их-20-ийн орнуудтай харилцахад үүсдэг цоорхой нөхөгдөж, түүнчлэн бусад үед сонирхлын бус гэж үздэг орнуудтай, эсвэл асуудалтай гэж үзэхүйц түншүүдтэйгээ харилцах боломж гардаг. Иймд АСЕМ-ын үеэр үзэл бодлоо албан бусаар солилцох хэлбэрийг хадгалж үлдэх хэрэгтэй ба ингэхдээ арга зүйн хувьд институтчилэлийг нь цаашид хөгжүүлэн сайжруулахуйц зохион байгуулалтыг бий болгож болно.

Гэвч ерөнхийд нь харвал тодорхой сэдвийн хүрээнд АСЕМ-ын бодит үр нөлөөг хэмжихэд бэрхшээлтэй. Байгууллагын буюу институцийн хувьд гаргасан амжилт, алдаагаар нь үр ашиг, тус нөлөөг нь хэмжих боломжтой байдаг. Энэ үүднээс харвал АСЕМ нь амжилт, эсвэл алдааны алийг ч гаргаагүй. Гэвч оролцогч гишүүдийн тоо нь эрчимтэй нэмэгдсэнийг ажихад уг чуулга уулзалтын эерэг чанар ба хэрэгцээ шаардлагыг харж болох юм. Харамсалтай нь нөгөө талаас АСЕМ хэт өргөжсөнөөс болж түүнийг чиглүүлэн явуулахад хэцүү, саармагдуу, сарниу ч гэмээр үр дүн ажиглагдах болов. Гэвч Ази-Европын хоорондох институцийн хэрэгцээ шаардлага өндөр хэвээр л байна.

АСЕМ-ын хамтын ажиллагаа болон бүтэц

АСЕМ гурван тулгуур багана дээр тогтдог - эдгээр нь эдийн засаг, улс төр, соёлын салбарууд юм. Хоёр жил тутамд болдог Санхүү, Эдийн засгийн яамдын сайд нарын улс төрийн ба ажлын хэсгүүдийн уулзалтын сацуу соёлын хамтын ажиллагааны салбарт чтогтвортой бүтэц ажиглагддаг. Ази-Европын Сан буюу АСЕФ нь АСЕМ-ын гишүүн орнуудын дунд оршиж буй цорын ганц бэхжсэн байгууллага юм. Сингапурт төвтэй уг сан нь гишүүн орнуудын соёлын интеграцийн хүрээнд хоёр болон олон талт төслүүдийг хэрэгжүүлдэг ба дэмждэг. Хамтын ажиллагааны өөр нэгэн арга хэлбэр нь улс төрийн мэргэжилтэн, шинжээчид хооронд явагддаг санал солилцох уулзалтууд юм. Түүнчлэн дээд хэмжээний чуулга уулзалтууд хооронд хүний эрхийг бэхжүүлэх, аялал жуулчлалыг дэмжих болон жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн талаарх семинарууд зохион байгуулагддаг.

Санхүүжилт

Одоогоор Ази, Европын дээд түвшний уулзалтыг зохион байгуулж буй тухайн орон тус арга хэмжээтэй холбоотой байр сууц, аюулгүй байдлын бүх зардлыг хариуцах зарчим үйлчилдэг. Харин орчуулагчид нь тус тусын орноос ирдэг. Гэсэн хэдий ч, тухайн зохион байгуулагч оронд АСЕМ-ын дээд түвшний уулзалтыг зохион байгуулахтайгаар холбогдон үүсч буй санхүүгийн ачааллыг дутуу үнэлж болохгүй. Соёлын салбарын АСЕФ нь гишүүн орнуудын жилийн татвар хураамжаар санхүүждэг. 1997-2014 онд хуримтлагдсан төсөв нь дөнгөж 79 сая евро болж байна. ХБНГУ нь үүнд онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Европын улс орнууд дотроос сүүлийн 18 жилд хамгийн их хандив өргөсөн орон болсон байна. Ерөнхийд нь авч үзвэл төслийн санхүүжилтэнд Япон улс болон ЕХ-ны төслийн хөрөнгө зонхилдог. Иймээс ХБНГУ өөрийн татвар төлөгчдийн өмнө хүлээсэн үүрэг болон даалгаврын дагуу АСЕФ болон АСЕМ-ын

ажилд илүү санаачлагатай оролцох ёстой юм.

Ази-Европын хэлэлцээг гүнзгийрүүлэх нь

Гүнзгийрүүлэх хэрэгцээ шаардлага

Гишүүдийнх нь үнэмлэхүй тоог нь авч үзвэл АСЕМ маш сонирхол татахуйц байгаа нь ажиглагдана. Иймд институтчилэлийг нь гүнзгийрүүлэх хэрэгцээ бий юу гэсэн асуудал хөндөгдөнө. Ялангуяа Европын талд АСЕМ нь Азийн эрчтэй хөгжилд оролцох, хамтран бүтээн байгуулалт бий болгох том боломжийг олгох юм. Энэ нь эцэстээ уг дээд түвшний уулзалтыг цааш нь хөгжүүлсэн цагт л биеллээ олно. Сүүлийн жилүүдэд АСЕМ нь илүү бодит үйл хэрэгт түшиглэсэн байх ёстой гэх санаа зонхилох болсон. Миланд болсон дээд түвшний уулзалтын үеэр төр, засгийн тэргүүд АСЕМ-ыг илүү үр дүнд чиглэсэн байх ёстой гэдэгт санал нэгдсэн. Харин үүнийг хэрхэн биелүүлэх вэ гэдэг нь тодорхойгүй хэвээр л байна.

АСЕМ-ын „нээлтэй бөгөөд зайлшгүй уягдах шаардлагагүй хүрээ” нь олон талаар шүүмжлэлд өртдөг бөгөөд угтаа энэ нь гишүүн орон тус бүрийн „ашиг сонирхлын олон төлөвт, нарийн төвөгтэй байдлаас” угшилтай юм. Гэсэн хэдий ч Европын холбооны гишүүн орнууд одоогоор дээд түвшний уулзалтыг Транс-Евразийн солилцооны урт хугацааны гол форум болгон төвхнүүлэх сонирхол багатай байгаа нь ажиглагддаг. Институтчилэх талаарх төрөл бүрийн санаачлага нь өнгөрсөн хугацаанд Европын Холбооны Комиссийн цааргалалт болон зардлын асуудлаас болж удаа дараа биеллээ олоогүй. Түүнчлэн Европын Комиссоос Европын Холбоо болон Азийн стратегийн түншлэлийн асуудлаар Европын Зөвлөл ба Европын Парламентад хандсан сүүлийн мэдэгдэлдээ АСЕМ-ыг огт дурдаагүй байна. Харин АСЕАН-ы орнуудтай харилцаагаа бэхжүүлэхийг чухалчилан дурдсан байгаа юм. Европын Холбоо доод түвшний албан бус хэлэлцүүлэг, ажлын хэсгийг өргөтгөх явдлыг сонирхож байгаа боловч, АСЕМ-ын албан бус шинж чанарыг бүхэлд нь хадгалах талаар нэгдмэл байр суурьтай байна. Энэ нь орчин цагийн геополитикийн сорилтуудад нийцээгүй байр суурийнх нь илрэл юм. Ойрхи Дорнодын хямралын голомт хийгээд үүнтэй холбоотойгоор үүсч буй дүрвэгсдийн шилжилт хөдөлгөөний асуудлыг Европын Холбоо дангаар шийдвэрлэх боломжгүй. Бүс нутаг дамнасан хямрал болон терроризмын эсрэг тэмцэлд Дундад болон Зүүн Азийн орнуудыг татан оролцуулах явдлыг АСЕМ-аар дамжуулан бий болгож болно. Германы талаас Азийн орнуудтай харилцаагаа улам гүнзгийрүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байгаа бөгөөд энэ нь эдийн засаг, улс төр, соёл гэсэн гурван баганын аль алинд ажиглагдана. Хятад, Энэтхэг, Япон, Солонгос зэрэг Германы Ази дахь дөрвөн том худалдааны түншүүдийн аль нь ч АСЕАН-ы гишүүн биш боловч АСЕМ-ын нэг хэсэг юм. ХБНГУ нь Азийн бүс нутаг дахь гадаадын томоохон хөрөнгө оруулагчийнхаа хувьд уг бүс нутгийн тогтвортой байдал, аюулгүй байдал, ардчиллыг хөгжүүлэх асуудалд бусдаас илүү анхаарал хандуулах ёстой. Үүнээс гадна Германд шилжин ирэгсдийн бараг гуравны хоёр нь АСЕМ-ын гишүүн орнуудаас уг гаралтай ба Турк Улс 2016 онд элсвэл уг тоо үлэмж нэмэгдэх болно. Ази тивийн улс орнуудад Европын гол хөдөлгүүр хэмээн үнэлэгддэг ХБНГУ нь үлгэр жишээч байх үүргийнхээ үүднээс төдийгүй, Азийн бүс нутагт эдийн засгийн,

**АСЕМ-ын дээд түвшний
ээлжит уулзалтыг эх
орондоо зохион
байгуулах гэж буй
Монгол улсын хувьд
харилцаагаа
гүнзгийрүүлэх чиглэл
нэн чухал байх учиртай.**

**АСЕМ-ын
институтчилэлийг
гүнзгийрүүлэн
урагшлуулснаар Монгол
улс Ази, Европын бусад
орнуудтай улс төр,
эдийн засаг, соёлын
салбарт хамтын
ажиллагаагаа
сайжруулах боломжтой
юм. Энэ нь зөвхөн
Монгол улсын хувьд
төдийгүй бусад
орнуудад ч эерэг үр
нөлөө үзүүлэх болно.**

АСЕМ нь анхаарал татахуйц томоохон яриа хэлэлцээний форумын байр сууриа алдахгүйн зэрэгцээ илүү үр дүнд чиглэсэн байхын тулд ямар ч тохиолдолд хэлэлцүүлгийн хүрээгээ бүх гишүүдийн санал солилцооны талбар хэвээр үлдээх хэрэгтэй.

улс төрийн, соёлын хүчтэй ашиг сонирхолтойгийнхоо хувьд АСЕМ-ыг гүнзгийрүүлэхийн төлөө илүү хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Азийн талаас АСЕМ-ыг институтчилэх сонирхол болон хичээл зүтгэл илүү их ажиглагддаг. Азиуд нэг талаас АСЕМ-ын онцлог шинж агуулгыг үнэлдэг ба нөгөө талаас АСЕМ-ын Нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулах зэргээр өнөөгийн дотоод зохицуулалтын дутагдалтай талуудыг засч болно хэмээн найдлага тавьж байна. АСЕМ-д барууны орнуудын төр, засгийн газрын зарим тэргүүд хангалтгүй оролцож ирсэн явдал хийгээд колончлолын өнгөрсөн үеэс болон өнөөгийн улс төрийн санал зөрүүтэй байдлаас улбаатай үл итгэлцэл зэрэг нь өнгөрсөн жилүүдэд Азийн түншүүдийн урмыг хугалж, төөрөгдүүлсэн тал бий. АСЕМ-ын дээд түвшний ээлжит уулзалтыг эх орондоо зохион байгуулах гэж буй Монгол Улсын хувьд харилцаагаа гүнзгийрүүлэх чиглэл нэн чухал байх учиртай. Монгол улс нь АСЕАН-ы гишүүн биш, Номхон далайн эдийн засгийн хэлэлцээр (Trans-Pacific Partnership-TPP) зэрэг бүс нутгийн худалдааны түншлэлийн хэлэлцээрт хамрагддаггүй бөгөөд олон улсын соёлын хэлхээ холбоо ч багатай. АСЕМ нь гурван тулгуур баганыг нэгтгэж байдаг: АСЕМ-ын институтчилэлийг гүнзгийрүүлэн урагшлуулснаар Монгол улс Ази, Европын бусад орнуудтай улс төр, эдийн засаг, соёлын салбарт хамтын ажиллагаагаа сайжруулах боломжтой юм. Энэ нь зөвхөн Монгол улсын хувьд төдийгүй бусад орнуудад ч эерэг үр нөлөө үзүүлэх болно.

Гүнзгийрүүлэх боломжүүд

Асуудлын гол нь аль хэдийн 53 гишүүнтэй болоод байгаа энэ байгууллага чухам яаж институтчилэлээ гүнзгийрүүлж чадах вэ гэдэгт оршиж байгаа юм. Зарчмын хувьд энэ нь зөвхөн хүчтэй институтчилэлд суурилж бий болно гэдэг нь тодорхой. Гэхдээ энэ нь энэхүү яриа хэлэлцээний форумын үндсэн санаа зорилгод харшлах ёсгүй. АСЕМ-д оршиж байгаа Евразийн интеграцийн үйл явцад саад болж болзошгүй олон тооны хүндрэл бэрхшээлийг тодорхой хэд хэдэн арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлснээр даван туулж болно.

Нарийн бичгийн дарга нарын газрыг бий болгох нь нэн тэргүүний алхам байж болох юм. Зохион байгууллалтынхаа түвшинг нэмэгдүүлсэнээр гишүүн улс орнууд өөрсдийн ашиг сонирхлыг зохицуулж, нэгдмэл санаанд хүрэх боломжтой болно. Түүнчлэн ингэснээр нэгдсэн нэг хэлэлцээний түнш бий болж олон талт гэрээ, хэлэлцээр байгуулах үйл хэргийг хялбарчилах болно. АСЕМ-ын Нарийн бичгийн дарга нарын газар нь дээд түвшний уулзалтуудыг бэлдэхээс гадна уулзалтууд хооронд агуулга тал дээр нь ажиллана. Үүний сацуу бүс нутгийн чухал байгууллагууд болох ЕХ болон АСЕАН-ы дэргэд төлөөллийн газраа нээвэл бүр ч ач холбогдолтой байх болно. Харин институтчилэлийг гүнзгийрүүлэх явцад албаны хүнд суртал болон санхүүгийн зардал нэмэгдэхийг анхаарах хэрэгтэй. Тиймээс санхүүжилтийн асуудлыг юун түрүүнд нухацтай авч үзэн, шийдвэл зохино. АСЕМ-ын зардлыг хүлээн авагч орон дааж, АСЕФ-ын санхүүжүүлж зөвхөн гишүүн орнуудын сайн дурын хандиваас бүрдэж байгаа одоогийн хуваарийг шинэчилэх хэрэгтэй. Үүний нэг арга нь АСЕМ-ын татвар, хандивын хэмжээг тухайн улсын нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн

болон нийт хүн амын тоог нь уялдуулан тогтоох явдал юм. Санхүүжилтийн асуудал бүхэлдээ төвөгтэй хэвээр байгаа бөгөөд гишүүн орнуудын хооронд маргаан үүсэхэд хүргэж байна.

АСЕМ нь анхаарал татахуйц томоохон яриа хэлэлцээний форумын байр сууриа алдахгүйн зэрэгцээ илүү үр дүнд чиглэсэн байхын тулд ямар ч тохиолдолд хэлэлцүүлгийн хүрээгээ бүх гишүүдийн санал солилцооны талбар хэвээр үлдээх хэрэгтэй. Үүний хүрээнд тодорхой сонирхлын чиглэлийнх нь дагуу улс орнуудын тусгай бүлгүүдийг бий болгож, улмаар тэдгээр нь АСЕМ-ын ивээл дор ажиллах боломжтой. Бүх хамтын ажиллагааны төрлүүдийг гишүүн орнуудын жижиг бүлгүүдээр дамжуулан урагшлуулаад байх боломжтой юм. Ингэснээр дээд түвшний бага уулзалтуудыг АСЕМ-ын дээд түвшний их уулзалтын нэг хэсэг болгон зохион байгуулж байж болох юм. Хэлэлцэх сэдэв бүр бүх улс орны сонирхолд нийцэх боломжгүй. Гэсэн хэдий ч, тодорхой улс орнуудын сонирхлыг татан, тэднийг хооронд нь холбож байдаг сэдэв ямагт байдаг. АСЕМ-ын бүтэц дотор ч холбоо, сүлжээд үүсгэж болох юм. Холбоо сүлжээдийн санаачилгууд нь АСЕМ-ын нэр дор хэрэгжих бөгөөд энэ нь гадаад ертөнц дэх АСЕМ-ын үзэгдэх байдлыг нэмэгдүүлнэ. Зохион байгуулалтын талаарх бодит саналуудыг Ёо Лая Хве (Yeо Lay Hwee) боловсруулан дэвшүүлжээ. Түүний төсөөллөөр чуулганы нээлтийн үеэр айлчлалын бүрэлдэхүүнүүд уулзаж, саналаа товч солилцох юм. Үүний дараагаар дөрвөөс таван тодорхой сэдвээр зэрэгцээ уулзалтууд зохиогдоно. Сэдвийг нь давхардсан саналын тоон дээр үндэслэн сонгох болно. Нэгдүгээрт, дэд уулзалтын сэдэвт Европ, Азийн шинж чанар хадгалагдаж байх үүднээс хамгийн багадаа Азийн гурав, Европын гурван орон сэдвийг батлах шаардлагатай. Хоёрдугаарт, сэдэв нь оролцогчдын олонхийн саналыг авах ёстой.

Миланы дээд түвшний уулзалтын үйл явц дээрх арга барилд ойртож байв. Тус уулзалтын үеэр 16 өөр сэдвээр гишүүн орнуудыг бүлэглэсэн жагсаалтыг баталсан байна. Ерөнхийд нь авч үзвээс Азийн орнууд хамтын ажиллагааг илүү урагшлуулах сонирхолтой байгаа нь ажиглагддаг. Энэтхэг улс арван нэгэн төсөлд оролцож байхад, Хятад улс зургаан төсөлд оролцох жишээтэй. Европын томоохон орнуудын оролцоо харин бага байгаа нь ажиглагдана. Жишээлбэл ХБНГУ ямар ч төсөлд нь оролцоогүй байна. Уулзалтад оролцогчдоо хоорондоо илүү идэвхтэй хэлэлцээ өрнүүлэх, үйл ажиллагаа явуулах боломжийг олгох үүднээс дээд хэмжээний уулзалтын форматыг өөрчлөх талаар ч мөн бодох хэрэгтэй. Энэ нь хэлэлцүүлгийг илүү бодитой болгох болно. Миланд үүний эхлэлийг амжилттай тавьсан байна: төр, засгийн тэргүүд ямар ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл оролцуулахгүйгээр, элдэв бичлэггүйгээр, орчуулгагүйгээр хоорондоо шууд хэлэлцээ хийсэн байна. Улаанбаатар хот дахь АСЕМ-ын уулзалтыг зохион байгуулагчид ч мөн энэ боломжийн талаар мэдэж байгаа. Тэд төр, засгийн тэргүүдийг олны хөлөөс ангид, гадаад хүчин зүйлс саад болохооргүй, албан бус орчинд яриа хэлэлцүүлэг явуулах нөхцлөөр хангахаар төлөвлөж байна.

АСЕМ нь оргилсон зах зээлийн талбар байх бүрэн боломжтой. Ази, Европын хоорондох худалдаа цаашид өссөөр байх юм бол

АСЕМ нь оргилсон зах зээлийн талбар байх бүрэн боломжтой. Ази, Европын хоорондох худалдаа цаашид өссөөр байх юм бол газар, усыг холбосон шинэ торгоны зам бодит үйл хэрэг болоход ойрхон байна.

Тус дээд хэмжээний уулзалт нь өдгөө хүртэл албан бус шинж чанартайгаар зохиогдож ирсэн ч, цаашид уг уулзалтыг институтчилж, гүнзгийрүүлэх алхам хийгдэх цаг нь ирсэн.

газар, усыг холбосон шинэ торгоны зам бодит үйл хэрэг болоход ойрхон байна. АСЕМ-ын гишүүн орнууд өсөн өргөжиж буй худалдаа болон хөрөнгө оруулалтын хэмжээгээ хүчтэй нэмэгдүүлэхийн тулд хоорондоо илүү холбогдож, харилцаагаа нягтаршуулах ёстой. АСЕМ нь Европ, Азийн үр өгөөжтэй худалдааг хөгжүүлэх, хамтын ирээдүйг цогцлооход тус болохуйц бодол санаа, мэдлэгээ солилцох талбар байх учиртай.

Институтчилэхэд зохистой өөр нэг салбар бол аюулгүй байдлын хамтын ажиллагааны талбарыг хүчирхэгжүүлэх юм. Эрчим хүчний аюулгүй байдлын бие даасан форумууд аль хэдийн зохион байгуулагддаг болсон ба цаашид яамд болон парламентын түвшинд уулзалтуудыг тогтмол зохион байгуулсанаар тулгамдсан глобал асуудлуудыг шийдэж, бүс нутгийн мөргөлдөөнийг зогсоох шийдлийг олох боломж нээлттэй юм.

АСЕМ-ын хүрээнд мөн иргэний нийгмийн салбарыг ч мэдэгдэхүйц өргөжүүлж болно. Анхны хэлбэр болох АСЕФ буюу Ази-Европын Сан нь соёл, оюун санааны солилцоог хөгжүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн. Гэвч үйл ажиллагаа нь ихэнхдээ жижиг хүрээний, богино хугацааны төслүүдээр хязгаарлагдаж байна. Эдгээрийг өргөжүүлж, хоёр тивийн харилцан ойлголцлыг төрөл бүрийн соёлын солилцоо дээр үндэслэн хөгжүүлэх нь нэн чухал юм. Трансатлантын олон талт соёлын түншлэл нь энэ тал дээр үлгэр жишээ болж чадна. Аль ч санал санаачлагын үед АСЕМ-ын аль нэг тулгуур баганыг нь хөгжүүлэхийн тулд нөгөө хоёр баганыг нь орхигдуулах ёсгүй гэдгийг санах хэрэгтэй.

Дүгнэлт

Улаанбаатарт зохиогдох 20 жилийн ойн уулзалт нь Ази-Европын яриа хэлцээний форумыг нэгэн чухал шийдвэрийн өмнө хөтлөж байна. Тус дээд хэмжээний уулзалт нь өдгөө хүртэл албан бус шинж чанартайгаар зохиогдож ирсэн ч, цаашид уг уулзалтыг институтчилж, гүнзгийрүүлэх алхам хийгдэх цаг нь ирсэн. Энэ нь зөвхөн зохион байгуулагч орны ашиг сонирхолд нийцэхээс гадна Азийн бусад орнуудад, бүр цаашлаад ХБНГУ-ын хувьд ч үр ашигтай байх болно. Үүнд хүрэх анхны алхам нь АСЕМ-ын Нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулах, цаашлаад АСЕМ-ын дээд түвшний уулзалтын албан бус шинж чанартай зохион байгуулалтыг институцийн хэв маягт оруулах, түүнчлэн аюулгүй байдлын салбар дахь гишүүн орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг юм. Улаанбаатар хотод болох ээлжит дээд түвшний уулзалт нь зарим нэг бэрхшээлтэй тулгарах боловч АСЕМ-ын 20 жилийн ойг тохиолдуулан олон улсын хамтын ажиллагааны энэ чухал форумыг шинэ түвшинд хүргэх хэрэгтэй.

Марк Хауптманн

ХБНГУ-ын Бундестагийн гишүүн бөгөөд Эдийн засаг, эрчим хүчний хорооны гишүүн

Ашигласан материал:

- Vgl. Yeo Lay Hwee, „The 10th ASEM Summit – Paving the Way Towards an Asia-Europe Marketplace?“, in: Wilhelm Hofmeister/Patrick Rueppel (Hrsg.), *The future of Asia-Europe cooperation*, Singapur, 2015
- Hanns Maull, „Das Asia-Europe Meeting (ASEM): Baustein effektiverer globaler Ordnungsstrukturen?“, in: Dirk Nabers (Hrsg.), *Multilaterale Institutionen in Ostasien-Pazifik: Genese - Strukturen - Substanz – Perspektive*, Wiesbaden, 2010
- Howard Loewen, „Das Asia-Europe Meeting (ASEM) – AkteureinerinternationalenOrdnungspolitik?“, *SüdostasienAktuell – Journal of Current Southeast Asian Affairs*, 25, 6/2006
- Bart Gaens, „ASEM in the Wake of the Milan Summit“, in: Wilhelm Hofmeister/Patrick Rueppel, *The Future of Asia-Europe Cooperation*, Singapur, 2015
- ASEF, „Annual Report. Financial Information“, <http://www.asef.org/ebooks/annualreport/2014/financial.php> [07.08.2015].
- Franz Kernic, *Die Außenbeziehungen der Europäischen Union: Eine Einführung*, Frankfurt am Main, 2007
- EU Kommission, pers. Komm., 19.05.2015
- Vgl. Bundeszentrale für politische Bildung, *Ausländische Bevölkerung nach Staatsangehörigkeit*
-<http://www.bpb.de/nachschlagen/zahlen-und-fakten/soziale-situation-in-deutschland/61631/staatsangehoerigkeit> [07.08.2015]
- Vgl. EviFitriani, „Asian perceptions about the EU in the Asia–Europe Meeting (ASEM)“, in: *Asia Europe Journal*, 2011, Bd. 9/1, 2011
- Jason Tan „Revitalising ASEM“, in: Wilhelm Hofmeister/Patrick Rueppel, *The Future of Asia-Europe Cooperation*, Singapur 2015

АСЕМ – МОНГОЛЫН ТАЛЫН БАЙР СУУРЬ

Конрад-Аденауэр-Сангийн энэхүү хүндэт танхимд миний бие хамгийн сүүлд энэ оны 3 дугаар сард Монгол Улсын Их Хурлын дарга, ноён Энхболдыг Монгол улс дахь ардчиллын хөгжлийн талаар сонирхолтой илтгэл сонордуулах үеэр хүрэлцэн ирсэн. Монгол улсын ардчиллын 25 жилийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, түүнчлэн бидний иргэний нийгмийн санаачилга болох



Монгол-Германы Чуулганыг олон жилийн турш тууштай дэмжиж ирсэн Конрад-Аденауэр-Санд хүрэлцэн ирэх надад үргэлж таатай санагддаг.

Илтгэлээ сонордуулж эхлэхээсээ өмнө илтгэлийн агуулгаа Монгол Улсын Засгийн газартай болон Монгол Гадаад Харилцааны Яамтай өмнө нь урьдчилан тохиролцоогүй болохыг сануулахыг хүсч байна. Өнөөдрийн энэхүү хуралд миний бие Улсын Их Хурлын Гишүүний болон Батлан Хамгаалахын болоод Гадаад Хэргийн Сайд байсан хүнийхээ хувьд оролцож байна. Монгол улс өнгөрсөн 25 жилийн хугацаанд аливаа намаас үл хамаарах, тогтвортой, залгамж чанартай гадаад бодлого баримталж, өөр хоорондоо зөвшилцөн эв нэгдэлтэй байх зарчмын дагуу ажиллаж ирсэн тул миний илтгэл Засгийн газрын албан ёсны байр суурьтай нэг их зөрөхгүй байх гэж найдаж байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 10-р зүйлд заасны дагуу Монгол улс нь энхийг эрхэмлэсэн гадаад бодлого хэрэгжүүлэх хийгээд олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг мөрдөх үүрэгтэй.

Үндэслэл ба зарчмууд

Монгол Улсын Үндсэн Хуулийн 10-р зүйлд заасны дагуу Монгол улс нь энхийг эрхэмлэсэн гадаад бодлого хэрэгжүүлэх хийгээ долон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг мөрдөх үүрэгтэй. Монгол улсын Гадаад болон аюулгүй байдлын бодлогын номнолын нарийвчилсан баримт бичиг нь 1994 онд Монгол Улсын Их Хурлаар батлагдсан ба 2010/2011 онуудад шинэчлэгдсэн.

Газар зүйн байрлалын хувьд Монгол улс Хятад, Орос гэсэн зөвхөн хоёр их гүрэнтэй хиллэдэг, далайд гарцгүй улс юм. Энэхүү геополитикийн нөхцөл байдлын улмаас бид 1990 оноос хойш "Гуравдагч хөршийн" бодлогыг тууштай хэрэгжүүлж байна. Тухайн үед (1990/1991) монголчууд бид "хувьсгал"-ын үр дүнд Москвад үнэнч бодлогоосоо богино хугацаанд, амжилттай салж чадсан билээ.

Монгол Улсын **Гадаад бодлогын үзэл баримтлалд** "Гуравдагч хөрш"-үүдийг тодорхой тэмдэглэсэн байдаг билээ. Тэдгээрт: АНУ, Япон, Европын Холбоо болон түүний гишүүн орнууд (түүн дунд Герман улс), Өмнөд Солонгос, Канад, Энэтхэг, Турк, Австрали болон бусад өндөр хөгжилтэй ардчилсан улс хийгээд холбоод багтсан байдаг. Монгол Улсын "Гуравдагч хөрш"-үүдэд өргөн утгаараа **НҮБ болон бусад олон улсын байгууллагууд** мөн багтана.

Сүүлийн 25 жилийн хугацаанд Монгол улс нь мөнхийн хоёр хөршөөсөө гадна дэлхийд олон түнш болон холбоотонтой

болсон. Монгол улсын олон улс дахь ач холбогдол, хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь энэ 25 жилийн турш тогтвортой өссөөр ирсэн. Бидний идэвхтэй хэрэгжүүлж ирсэн гадаад бодлогын үр дүнд Монгол улсын тусгаар тогтнол, улс төрийн хараат бус байдлыг хангах зорилт бүхий "Гуравдагч хөршийн" бодлогын эн тэргүүний улс төрийн зорилтууд аль хэдийн биеллээ олжээ.

Ололт амжилтын саяхны зарим жишээг дурьдвал:

- Миний бие Батлан хамгаалахын сайд байх үед Монгол улс нь НАТО-гийн хамтын ажиллагааны хөтөлбөрт нэгдсэн (2011 оны 3 дугаар сард).
- 2012 оны 12 дугаар сард буюу миний бие Гадаад хэргийн сайдын албыг хашиж байх үед Монгол улс нь Европын Аюулгүй Байдлын Хамтын Ажиллагааны Байгууллагын (ЕАБХАБ) 57-р гишүүнээр элссэн. Тухайн үед Холбооны Засгийн газраас үзүүлсэн дэмжлэг маш чухал агаад үнэтэй байсныг дурдах нь зүйтэй.
- Европын Холбооны Гадаад болон аюулгүй байдлын бодлогын асуудал эрхэлсэн дээд төлөөлөгч хатагтай Эштон болон миний бие Гадаад хэргийн сайд байхдаа 2013 оны 4 дүгээр сард Монгол улс, Европын Холбоо хооронд Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурсан.
- Саяхан Монгол Улс нь олонхийн саналаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд сонгогдсон.

Хэдийгээр бид олон зорилтоо биелүүлж чадсанч, Монгол улс гадаад бодлогын болон гадаад эдийн засгийн тэнцвэртэй байдлаа хадгалах үүднээс цаашид ч "Гуравдагч хөршийн" бодлогоо тууштай үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй гэж миний бие үзэж байна. „Танилтай бол талын чинээ” гэсэн монгол ардын зүйр цэцэн үг бий. Монгол улс хоёр том хөрштэйгээ сайн, нөхөрсөг хөршийн харилцаагаа үргэлжлүүлэхийг эрмэлздэг нь тодорхой. Энэ нь манай орны хувьд амин чухал асуудал. Түүнээс гадна Монгол улс нь "Гуравдагч хөршүүдтэйгээ" түншлэлийн болон харилцан итгэлцлийн харилцаагаа хөгжүүлэх хүсэлтэй. Дээрх өнцгөөс Монгол улсын АСЕМ-ын талаарх байр суурь, хандлагыг тодорхойлохыг хичээх нь зүйтэй болов уу.

Монгол улсын "Гуравдагч хөршид" барууны өндөр хөгжилтэй, ардчилсан орнуудын сацуу өргөн утгаараа **НҮБ, ЕАБХАБ бусад олон улсын байгууллага, механизмууд** түүний дотор АСЕМ багтдаг гэдгийг би дахин тэмдэглэе. Монгол улсын АСЕМ дахь идэвхтэй оролцоо нь Монголын орчин цагийн гадаад бодлогын "Гуравдагч хөршийн" бодлоготой бүрэн нийцэж байна.

АСЕМ ба Монгол Улс

Бүс нутгийн талаас нь авч үзвэл Монгол улс 2008 оноос хойш АСЕМ-ын гишүүн орнуудын эгнээнд багтаж байна. Үүний арай өмнө нь буюу 2004 онд Монгол улс нь Шанхайн Хамтын Ажиллагааны байгууллагад (ШХАБ) ажиглагчийн статустай болсон. Монгол улс нь хэдэн жилийн турш АСЕАН-ы Бүсийн чуулга уулзалтад идэвхтэй оролцож байна. Монгол улс нь АПЕК

Сүүлийн 25 жилийн хугацаанд Монгол улс нь мөнхийн хоёр хөршөөсөө гадна дэлхийд олон түнш болон холбоотонтой болсон.

Монгол улс хоёр том хөрштэйгээ сайн, нөхөрсөг хөршийн харилцаагаа үргэлжлүүлэхийг эрмэлздэг нь тодорхой. Энэ нь манай орны хувьд амин чухал асуудал. Түүнээс гадна Монгол улс нь "Гуравдагч хөршүүдтэйгээ" түншлэлийн болон харилцан итгэлцлийн харилцаагаа хөгжүүлэх хүсэлтэй.

**Монгол орныг мэдэх
хүмүүс манай орныг
газар зүйн хувьд Азид
оршдог гэдгийг мэднэ.
Гэвч олон монголчуудын
оюун санаа нь европтой
илүү ойр байдаг.**

**Иймээс АСЕМ нь Монгол
улс шиг гадаад
бодлогын чиглэлтэй,
зарим талаараа Европт
ээлтэй, Азийн оронд
өөрийн гадаад бодлогын
зарим зорилтоо
хэрэгжүүлэх боломжийг
олгох тавцан нь юм.**

(APEC-Asia-Pacific Economic Cooperation) буюу Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элсэх өргөдлөө хэдэн жилийн өмнө хүргүүлсэн бөгөөд бид шинэ гишүүд элсүүлэх хугацаа нь дуусахыг хүлээж байна. Дээр дурдсанчлан ЕАБХАБ нь европын аюулгүй байдлын байгууллага хэдий ч, Монгол улс 2012 оны 12 дугаар сараас хойш тус байгууллагад гишүүнээр элссэн.

Эдгээр жишээнээс Монгол улс нь аюулгүй байдлын болон эдийн засгийн бодлогынхоо хүрээнд Азийн болон Европын бүс нутгийн болоод олон улсын бүтцүүдэд нэгдэхийг эрмэлзэж буйг ажиглаж болох юм.

Монгол орныг мэдэх хүмүүс манай орныг газар зүйн хувьд Азид оршдог гэдгийг мэднэ. Гэвч олон монголчуудын оюун санаа нь европтой илүү ойр байдаг. Энгийн нэг жишээ дурдахад герман хэлтэй, европын соёлд нэвтэрсэн 30000 орчим монголчууд байдаг. Энэ тоон дээр Зүүн Европ болон ОХУ-д суралцаж байсан мянга мянган монголчууд нэмэгдэнэ. Монгол улсын Европт элгэмсэг байдлын нэгэн тод жишээ бол манай улсын бүхий л гадаад болон дотоод бодлогод аажмаар Европын Холбооны хэм хэмжээ, стандартыг нэвтрүүлж байгаа явдал юм.

Иймээс АСЕМ нь Монгол улс шиг гадаад бодлогын чиглэлтэй, зарим талаараа Европт ээлтэй, Азийн оронд өөрийн гадаад бодлогын зарим зорилтоо хэрэгжүүлэх боломжийг олгох тавцан нь юм. Европ, Ази тив хоорондын улс төрийн болон соёлын харилцан ойлголцлыг яриа хэлэлцээний үр дүнд нэмэгдүүлэх, эдийн засгийн салбар дахь хамтын ажиллагааг харилцан ашигтайгаар нэмэгдүүлэх нь АСЕМ-ын уг зорилго мөн. Энэ нь Монгол улсын энхийн гадаад бодлогын үндсэн чигт мөн бүрэн нийцэж байна. Монгол улс нь Европ, Азийн хоорондох гүүр болон ажиллах бүрэн боломжтой.

АСЕМ-ын үйл ажиллагаан дахь Монгол улсын оролцооны зарим жишээ

Монгол Улс нь дээр дурдсанчлан 2008 онд Бээжин хотноо зохиогдсон АСЕМ-ын 7 дугаар дээд хэмжээний уулзалтаар АСЕМ-д гишүүнээр элссэн. Үүний дараагаар Монгол улс нь 2010, 2012 болон 2014 онд болсон 8, 9 болон 10 дугаар АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтад оролцсон байна. Түүнчлэн Монгол улс нь АСЕМ-ын Гадаад хэргийн, Сангийн болон Байгал орчны сайд нарын уулзалтад, мөн АСЕМ-ын Ази-Европын Залуу парламентчидын чуулганд тогтмол оролцсон байна.

Сүүлийн үед (2014 оноос хойш) Монгол улс нь АСЕМ-ын хүрээн дэх төрөл бүрийн олон талт уулзалт, хуралд маш идэвхтэй оролцсон. Тухайлбал:

- 2014 оны 7 дугаар сард ОХУ-ын Санкт-Петербург хотноо „Inter-Cultural and Interfaith Dialogue“ сэдвээр зохиогдсон дээд түвшний төлөөлөгчдийн бага хурал
- 2014 оны 7 дугаар сард Шанхай хотноо „ASEM Think Tank Symposium-Connectivity to Boost ASEM Cooperation“ сэдвээр зохиогдсон симпозиум (Монгол улс нь энэхүү симпозиумыг БНХАУ, Европын Холбоо, Польш, Сингапуртай хамтран зохион байгуулсан)

- 2014 оны 9 дүгээр сард Итали улсын Милан хотноо зохиогдсон Ази, Европын Сангийн сайд нарын уулзалт
- 2015 оны 4 дүгээр сард Латви улсын Рига хотноо зохиогдсон Боловсролын болон Зам тээврийн сайд нарын уулзалт
- 2015 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Сэргээгдэх эрчим хүчний талаарх семинар
- Өнгөрсөн оны 11 дүгээр сарын эхээр Люксембург хотноо зохиогдсон АСЕМ-ын орнуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалт. Үүнд миний албаны залгамжлагч оролцсон.

2016 онд маш олон арга хэмжээнүүд төлөвлөгдөөд байна: АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт болохын өмнө буюу 2016 оны 6 дугаар сарын сүүл, 7 дугаар сарын эхээр Улаанбаатар хотноо Ази-Европын Парламентын түншлэлийн 9 дүгээр чуулган болно. Хоёр сарын өмнө үүнтэй ижил төстэй нэгэн арга хэмжээ болох ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн намрын чуулганыг бид Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа.

Монгол улсын хүлээлт болон хүсэлт

Дэлхий нийт, Европ болон Ази тив, Герман болон Монгол улс нь өнөө цагт томоохон сорилтуудтай нүүр тулгарч байна. АСЕМ-ын 53 гишүүн орон дунд Европын холбоо, Герман, Франц, Орос, Хятад, Япон, Энэтхэг зэрэг дэлхийн нөлөө бүхий тоглогчид байна.

Монгол улсын туйлын сонирхол, хамгийн дээд зорилго нь Монгол улсад ардчиллыг бүрэн утгаар нь хөгжүүлэн бататгах, Монголын ард түмэн, иргэн бүрийг сайн сайхан амьдруулах, эрх чөлөө, шударга ёсыг хангахад оршино.

Улс төрийн салбарт, Монгол улсын ардчиллын хөгжилд Европын Холбооны нөлөө асар их ач холбогдолтой. Монгол улс, Европын Холбооны хоорондох Түншлэл, Хамтын Ажиллагааны Хэлэлцээр, Европын Холбооны норм, стандарт ч бас үүнд хамаарна. Конрад-Аденауэр-Сан нь Монголд барууны ардчиллын үнэт зүйлийг дэлгэрүүлэхэд үлгэр жишээч байдлаар ажиллаж буй байгууллага юм.

Монголын эдийн засгийн хөгжилд Хятад, Орос улсууд нь маш чухал ач холбогдолтой. Бидний дунд хоёр талт болон гурван талт хэлэлцүүлгүүд хэдэнтээ өрнөсөн. Гэхдээ Монгол улсын эдийн засгийн бүтээн байгуулалтанд оролцоход Европ, Ази, АНУ болон бусад тоглогчдын хувьд ч бүрэн нээлттэй. Тодруулбал, Монгол улсад орчин үеийн дэд бүтцийг хурдацтай бий болгоход болон эдийн засгийн салбаруудыг төрөлжүүлэхэд гадаад түншүүдийн маань хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр дээрх хүрээн дэх тодорхой санал санаачлагуудыг гаргаснаар хамтын ажиллагааны үндэс суурь маань амжилттай тавигдах боломжтой. Европ, Хятадын хоорондох агаарын тээвэр үүний нэг сайн жишээ болно. Монгол улсын агаарын зам энэ чиглэлд хязгаарлалтгүйгээр дамжин өнгөрүүлэх зарчмаар ажиллаж байна. Гэвч бидэнд төмөр зам, авто зам болон газрын тос, байгалын хий дамжуулах хоолой, түүнчлэн эрчим хүчний шугам зэргийг Монгол улсын нутаг дэвсгэрт хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна. Эдгээрийн хөгжил нь алсдаа Европ болон Азийн харилцаа холбооны шугамыг сайжруулахад хувь

Монгол улсын туйлын сонирхол, хамгийн дээд зорилго нь Монгол улсад ардчиллыг бүрэн утгаар нь хөгжүүлэн бататгах, Монголын ард түмэн, иргэн бүрийг сайн сайхан амьдруулах, эрх чөлөө, шударга ёсыг хангахад оршино.

нэмэртэй юм.

АСЕМ-ын дээд хэмжээний уулзалттай холбоотой өөрийн үндсэн санаа, төсөөлөл, хүлээлт болон эргэцүүллээ би ийнхүү дээр илэрхийллээ.

2016 оны АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт нь бидэнд гадаадын зочид болон дэлхий нийтэд эх орноо эерэгээр таниулах, Монголын уламжлалт болон орчин үеийн соёл, монголчуудын ахуй амьдралыг танилцуулах зэрэг олон сайхан боломжийг олгож байгааг эцэст нь нэмж тэмдэглэмээр байна.

Анхаарал хандуулсанд тань талархал илэрхийлье.

Лувсанвандангийн Болд

МУ-ын УИХ-ын гишүүн бөгөөд УИХ дахь Монгол-Германы Парламентын бүлгийн дарга

АСЕМ - ГЕРМАНЫ ТАЛЫН БАЙР СУУРЬ

Эрхэм хүндэт хатагтай ноёд оо,

юуны өмнө энд надад үг хэлэх боломж олдож байгаад талархаж буйгаа илэрхийлье. Бид өнөөдөр үүсэн байгуулагдсанаасаа хойш 20 жилийн нүүр үзэж буй, ирэх жил Монгол оронд зохион байгуулагдах АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын талаар хэлэлцэж байна. Монгол-Германы Чуулган нь өөрөө олон жилийг ардаа үдэж, аль хэдийн бэхжиж төлөвшсөн, нэр хүндтэй байгууллага билээ. Өнөөдөр маш олон танил хүмүүсээ энд дахин хараад сэтгэл их хөдөлж байна.

Монгол-Германы Чуулган, АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт зэрэг ийм төрлийн яриа хэлэлцээ нь тодорхой бодит шийдвэр гаргадаггүйн улмаас олон улсын харилцаан дахь нарийн ач холбогдол нь тодорхойгүй байдаг. Гэсэн хэдий ч ийнхүү өөр хоорондоо санаа бодлоо солилцох нь бусад олон байгууллагад шийдвэр гаргах замыг нь нээж өгдөг учраас ач холбогдлыг нь дутуу үнэлж болохгүй.

Энэ нь улс төрийн дээд түвшинд хэлэлцүүлэг өрнүүлдэг олон улсын томоохон арга хэмжээ болох АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтанд, мөн манай хоёр орны хоёр талт харилцааны хүрээнд зохион байгуулагддаг Монгол-Германы Чуулганд ч ялгаагүй хамаатай болно. Сүүлийн хэдэн жил энэ форумд шинэлэг чиглэл тодорхойлсон, хоёр талт харилцааны маань хөгжилд түлхэц болохуйц сэдвүүд жаахан дутагдаад байна уу гэсэн бодол надад төрж байлаа. Харин энэ жил бид Монгол улсад хийгээд Герман улсад маш өндөр ач холбогдолтой 2016 онд Монголд болох АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын талаарх чухал сэдвийн хүрээнд хуралдаж байна.

Энэхүү дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулж байгаа Монгол улсад баяр хүргэе. Уг уулзалт Монгол улсын олон улсын харилцаан дахь байр суурийг нэмэгдүүлэх болон дэлхий нийт Монгол улсыг илүүтэй танин мэдэхэд томоохон үүрэг гүйцэтгэх нь баттай.

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

Герман улсын хувьд ч АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт нь Азийн орнуудтай харилцах харилцаа холбооных нь хамгийн чухал яриа, хэлэлцээний талбар юм. Түүнчлэн Ази тивийн өсөн нэмэгдэж буй улс төрийн болон эдийн засгийн ач холбогдлоос шалтгаалан Европ, нэн ялангуяа Герман улсын хувьд тус тивийн ач холбогдол нь урьд өмнөхөөс өссөн ба энэ нь цаашид ч үргэлжлэн нэмэгдэх хандлагатай байна.

Европын болон Азийн орнууд эдийн засгийн салбарт урьд өмнөхөөсөө илүү өөр хоорондоо нягт холбогджээ.



АСЕМ-ын гишүүн орнууд өнөөдөр дэлхийн нийт хүн амын 60 хувь, мөн үүнтэй дүйцэхүйц дэлхийн нийт худалдааны хувийг эзэлдэг ба бид дэлхийн эдийн засгийн үзүүлэлтийн 50-иас илүү хувийг бүрдүүлж байна.

**Европ тив нь зуу гаруй
жилийн өмнө дэлхийн
бодлогын төв байсан
бол аажмаар захруу
шахагдаж, Зүүн-Өмнөд
Ази нэн ялангуяа хүч
түрэн орж ирж байна.**

Өнөөгийн байдлаар Ази тивд европчууд биднээс илүү хөрөнгө оруулж буй хүмүүс алга. Түүнчлэн азийн хөрөнгө оруулагчдаас илүү Европт хөрөнгө оруулж буй хүмүүс үгүй.

АСЕМ-ын гишүүн орнууд өнөөдөр дэлхийн нийт хүн амын 60 хувь, мөн үүнтэй дүйцэхүйц дэлхийн нийт худалдааны хувийг эзэлдэг ба бид дэлхийн эдийн засгийн үзүүлэлтийн 50-иас илүү хувийг бүрдүүлж байна. Ази тив бол дэлхийн эдийн засгийн хөдөлгүүр юм. Герман улс нь экспортод чиглэсэн эдийн засагтай орны хувьд Ази тивтэй эдийн засаг ба худалдааны харилцаагаа гүнзгийрүүлэх онцгой сонирхолтой.

Түүнээс гадна АСЕМ нь Их-20 дээд хэмжээний уулзалтын гишүүн улсуудаас л гэхэд 12 улсыг эгнээндээ багтаажээ. Их-20 дээд хэмжээний уулзалт нь Их-7 дээд хэмжээний уулзалтыг дэлхийн эдийн засаг ба санхүүгийн бодлогын хэлэлцээний чухал талбараас халж байх хооронд АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт нь түүнд дагалдах эсвэл бэлтгэх уулзалт болж буйнхаа хувьд ач холбогдол нь улам өссөөр байна.

Ази тив нь хүчтэй эдийн засаг, нийгмийн үзүүлэлтээрээ дэлхийн аль ч тивийн түүхэнд байгаагүй удаан хугацаанд өндөр өсөлттэй байна. Эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшилд Европ тив нэг зуун жил эсвэл түүнээс ч удаан хугацааг зарцуулсан бол эдүгээ зарим азийн орнууд энэ хөгжлийг хэдэн арван жилийн дотор л бий болгож байна.

Ядуурлыг эрчтэй бууруулж буй нь энэ хөгжлийн хамгийн гайхалтай хүмүүнлэг үр дүн болно. Өнгөрсөн 20 жилд зөвхөн Хятадад л гэхэд хэдэн зуун сая хүн ядуурлаас ангижирчээ. Үүний зэрэгцээ Азийн хөгжил нь томоохон сорилтуудтай нүүр тулгарч байна. АСЕМ-ын уулзалт нь эдгээр сорилтын хэмжүүр болон хөгжиж ирсэн. Парист болох цаг уурын өөрчлөлт, дэлхийн дулаарлын дээд хэмжээний уулзалтыг угтаж, АСЕМ-ын гадаад хэргийн сайд нарын нарын уулзалтаар цаг уурын өөрчлөлтийн талаарх асуудлыг нэг чухал сэдэв болгон хөндсөн нь санаандгүй тохиолдол биш юм.

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад дэлхийн улс төр ч мөн Ази тив рүү жин даран чиглэж байна. Европ тив нь зуу гаруй жилийн өмнө дэлхийн бодлогын төв байсан бол аажмаар захруу шахагдаж, Зүүн-Өмнөд Ази нэн ялангуяа хүч түрэн орж ирж байна. Эрх мэдлийн өөрчлөлттэй зэрэгцээд эргэлзээтэй олон асуудал гарч ирдэг нь байгалын жам ёс юм. Газар нутгийн маргаан нь хязгаарлагдмал түүхий эдийн нөөцийн төлөөх тэмцлийн нэгэн адил зөрчилдөөний үндэс болох магадлалтай.

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад дэлхийн улс төр ч мөн Ази тив рүү жин даран чиглэж байна. Европ тив нь зуу гаруй жилийн өмнө дэлхийн бодлогын төв байсан бол аажмаар захруу шахагдаж, Зүүн-Өмнөд Ази нэн ялангуяа хүч түрэн орж ирж байна. Эрх мэдлийн өөрчлөлттэй зэрэгцээд эргэлзээтэй олон асуудал гарч ирдэг нь байгалын жам ёс юм. Газар нутгийн маргаан нь хязгаарлагдмал түүхий эдийн нөөцийн төлөөх тэмцлийн нэгэн адил зөрчилдөөний үндэс болох магадлалтай.

Үүний сацуу улс орнуудын нийгмүүд улам хүчтэйгээр өөр хоорондоо холбогдож байна. Үүний үр дүнд сонгодог төрийн

оролцоо бүрэн орлогдохгүй ч, тэдний үүрэг оролцоо зөвхөн туслалцаа дэмжлэгийн хэлбэрээр төдийгүй олон улсын байгууллага, сүлжээгээр дамжин нөхөгдөх болжээ. АСЕМ нь тэрхүү холбоо сүлжээний үйл явцыг дээд хэмжээний төвшинд харуулж байна.

Эрхэм хатагтай, ноёд оо,

АСЕМ нь үүсч хөгжсөнөөсөө хойшхи 20 жилийн хугацаанд дорвитой өөрчлөгдсөн. АСЕМ нь Европын Холбоо болон Зүүн-Өмнөд Азийн улс орнуудын хоорондох харилцаа холбооны платформ болон гараагаа эхлүүлж байсан ба Хятадын өсөлт дэвшилтэд олон талт хариу үйлдэл үзүүлэх нь тус яриа хэлэлцээний форум бий болох нэг шалтгаан нь байв. Үүнээс хойш энэхүү яриа хэлэлцээний талбарын сэдэв хэрхэн өргөжин, тэлсэн нь түүний бэхжилтийг илтгэж байна. 2008 онд Өмнөд Ази болон Монгол улсыг, 2010 онд Орос улсыг, 2014 Казахстан улсыг эгнээндээ нэгтгэсэнээрээ, түүнчлэн урьдчилсан таамгаар Турк болон Украин улсыг элсүүлвээс АСЕМ нь, Ойрхи Дорнодыг эс тооцвол, Евроазийн бүс нутгийг бүхэлд нь хамарсан яриа хэлэлцээний форум болох төлөвтэй байна.

АСЕМ нь Евроази дахь олон талт хэлэлцээг бэхжүүлдэг. Евроазийн улс орнуудын нэгдмэл байдал, ашиг сонирхлоос илүүтэй тэдгээр улс орнуудын олон талт байр суурь нь АСЕМ-ын ач холбогдлыг илтгэдэг. АСЕМ-ын гишүүн орнууд олон том сорилтой нүүр тулгарч байгаа ба үүний зэрэгцээ өөр хоорондоо маш ялгаатай ашиг сонирхлыг агуулж байна.

АСЕМ нь дэлхийн өнөөгийн улс төрийн эрх мэдэл бүхий 6 том гүрнийг нэгтгэж байна. Тэднийг хамгийн хүчирхэгээс нь эхлэн нэрлэвэл дэлхийн гүрэн Хятад, мөн дэлхийн гүрэн болох нөөц бололцоотой Энэтхэгийг тэмдэглэж болох юм. Эдгээр улсууд дээр нэмээд Европын Холбоо, Япон улс, АСЕАН болон өдгөө Европоос илүүтэй Ази руу чиглэсэн хүчтэй бодлого явуулж буй ОХУ-г нэрлэх нь зүйтэй.

АСЕМ нь аж үйлдвэржилт өндөр хөгжсөн боловч харьцангуй зогсонги байдалд орсон, хөгширч буй Япон мөн Европын улс орнуудыг эгнээндээ нэгтгэдэг. Үүний зэрэгцээ эрчимтэй өсч буй боловч нийгмийн ялгаа ихтэй хөгжиж буй орнууд ч мөн АСЕМ-ын гишүүд юм. АСЕМ-ын гишүүн орнууд өөр хоорондоо маш ялгаатай өвөрмөц үнэт зүйлс дээр түшиглэж дотоод болон гадаад бодлогоо хэрэгжүүлдэг.

Бид эдгээр ялгаа нь АСЕМ-ын мөн чанар, үнэ цэнийг бий болгодог гэдгийг сайтар ухамсарлах хэрэгтэй. Бидний үндсэн зорилго эдгээр олон талт ашиг сонирхлыг тайван замаар тэнцүүлж, дэлхий нийтийн өмнө тулгамдаад буй сорилтуудыг хамтран даван туулахад оршино.

Иймд олон улсын байгууллага болох бус яриа хэлэлцээний форумын үүргээ цаашид гүйцэтгэх АСЕМ-ын анхны концепцийг хадгалж үлдэхийг миний хувьд илүүд үзэж байна. Тиймдээ ч үүсгэн байгуулагдаад 20 жилийн нүүрийг үзэж байгаа АСЕМ-ын хөгжлийг хэр институтчилэгдсэн байна гэхээс илүү хэлэлцэх сэдвийн цар хүрээ нь хэрхэн өргөжсөн байгаагаар нь хэмжих нь зүйтэй. АСЕМ нь хоёр жил тутамд болдог энэхүү дээд хэмжээний

Евроазийн улс орнуудын нэгдмэл байдал, ашиг сонирхлоос илүүтэй тэдгээр улс орнуудын олон талт байр суурь нь АСЕМ-ын ач холбогдлыг илтгэдэг.

АСЕМ-ын үндсэн мөн чанар нь санаа бодлоо нээлттэйгээр албан бусаар солилцож, шийдвэр гаргахад бэлтгэх, улмаар үндэсний болон олон улсын түвшний хороодоор асуудлууд шийдэгдэх суурийг нь тавихад орших ба цаашдаа ч энэ хэвээрээ байх нь зүйтэй. Түүнээс биш дээр нь нэмж шийдвэр гаргах зөвлөл, хороо байгуулах шаардлагагүй гэж үзэж байна.

**АСЕМ-ын гишүүн орнууд
өөрсдийн хувийн ашиг
сонирхлоо урьтал
болгохын оронд
мөргөлдөөнийг даван
туулах эсвэл хүчийг нь
сулруулах тал дээр
хүчээ нэгтгэн хамтран
ажилласнаар асуудал
илүү хялбар шийдэгдэх,
эсвэл ядаж л буурах
боломжтой.**

уулзалтаар хязгаарлагдахгүй. Эдгээр дээд хэмжээний уулзалтууд нь өөр хоорондоо нягт холбоотой ажилладаг сайд нарын уулзалтуудаар нэмэн баяжигддаг. АСЕМ-ын үндсэн мөн чанар нь санаа бодлоо нээлттэйгээр албан бусаар солилцож, шийдвэр гаргахад бэлтгэх, улмаар үндэсний болон олон улсын түвшний хороодоор асуудлууд шийдэгдэх суурийг нь тавихад орших ба цаашдаа ч энэ хэвээрээ байх нь зүйтэй. Түүнээс биш дээр нь нэмж шийдвэр гаргах зөвлөл, хороо байгуулах шаардлагагүй гэж үзэж байна.

Эрхэм хатагтай, ноёд оо,

Герман улс АСЕМ-ын хүрээнд ямар асуудлуудыг онцгойлон сонирхож байгаа талаар тэмдэглээд илтгэлээ төгсгөө.

Нэгдүгээрт, Герман Улс экспортын эдийн засаг нь хүчтэй хөгжсөн аж үйлдвэрийн орон тул Азийн улс орнуудтай худалдааны харилцаагаа хөгжүүлэх эн тэргүүний сонирхолтой байгаа нь ойлгомжтой байх. Үүний тулд бидний зүгээс худалдааны саад тогторыг багасгахын сацуу, шударга өрсөлдөөний зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна. Түүхий эдийн худалдааны салбарт ч мөн энэ зарчмын дагуу асуудлыг шийдвэрлэснээр цаашид хязгаарлагдмал нөөц баялгийн төлөөх зөрчил маргаан гарахаас сэргийлж чадна.

Хоёр дахь чухал сэдэв нь цаг уурын өөрчлөлт болон тогтвортой хөгжлийн асуудлууд юм. АСЕМ-ын өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн орнууд болон эрчимтэй хөгжиж буй орнууд өөр хоорондоо хэлэлцүүлэг өрнүүлж, ашиг сонирхлоо тэнцүүлэх нь дэлхий нийтийг хамарсан асуудлуудын шийдлийг гаргахад амин чухал болно.

Гурав дахь сэдэв нь ирээдүйд эн тэргүүнд тавигдах зөрчилдөөнийг хэрхэн даван туулах талаарх асуудал болно. Энэ асуудлыг миний бие олон өнцгөөс харж байна. Юуны өмнө бид терроризмын эсрэг хамтран тэмцэх шаардлагатай. Зарчмын хувьд энэ асуудал нь маргаангүй урагшлах учиртай ба бид энэ асуудлын хүрээнд аль хэдийн олон төрлийн арга хэмжээ авч байна. Бодит амьдрал дээр харин хэнийг террорист гэж үзэх вэ, тэдэнтэй тэмцэх ямар арга барилууд зөвшөөрөгдсөн бэ, мэдээллийг хэрхэн цуглуулж, цааш нь дамжуулах вэ гээд өөр олон төрлийн асуултууд нээлттэй хэвээр л байна. Бид эдгээр асуултын хариуг үргэлжлүүлэн эрэлхийлж, толгойгоо ажиллуулах хэрэгтэй.

Зөрчилдөөний шалтгаан болон түүний үр дагаврыг хэрхэн даван туулах талаарх асуудал нарийн төвөгтэй. Герман улсад дүрвэгсэд асар их хэмжээгээр шилжин ирж байгаагаас болоод манай орон энэ асуудалд шууд өртөж байна. Герман улс иргэний дайнаас дажин нүүдэллэгч олон тооны дүрвэгсдийг хүлээн авч, өөрийн хүмүүнлэгийн үүргээ биелүүлж байгаа билээ. Дүрвэгсдийн урсгал энэ цар хүрээгээрээ удаан хугацаанд үргэлжилвэл бидний хүчин чадлаас хэтрэх болно.

Улс орноосоо дүрвэх шалтгааныг нь шийдвэрлэхгүй л бол энэ асуудал урт хугацаанд ямар ч шийдэлгүй. Сирид болж буй зөрчлөөс гадна Афганистан болон Пакистан улсуудад ч мөн зэвсэгт мөргөлдөөнүүд өрнөж байна. Бид АСЕМ-ын гишүүн,

хамтран зүтгэгчидээ ч мөн үүний эсрэг тэмцэх өндөр үүрэг хариуцлагатай гэж харж байна. Учир нь АСЕМ-ын гишүүн орнууд өөрсдийн хувийн ашиг сонирхлоо урьтал болгохын оронд мөргөлдөөнийг даван туулах эсвэл хүчийг нь сулруулах тал дээр хүчээ нэгтгэн хамтран ажилласнаар асуудал илүү хялбар шийдэгдэх, эсвэл ядаж л буурах боломжтой.

Одоогоор Азийн бүс нутгийн зөрчлийг шийдвэрлэх тал дээр хийх ажил олон байна гэж миний хувьд харж байна. Үүнд Энэтхэг, Пакистаны хоорондын зөрчил, Энэтхэг, Хятадын хоорондох газар нутгийн маргаан, Хойд Солонгосын асуудал, мөн Хятадын Өмнөд тэнгис дэх газар нутгийн маргааны асуудлууд багтана.

Мэдээж дээрх асуудлуудтай холбоотой ихэнх улс орон өөрсдийн хараат бус болон бүрэн эрхт байдлын талаар АСЕМ шиг олон улсын чөлөөт хэлэлцүүлгийн үеэр нарийвчлан хэлэлцэхэд бэлэн бус байгаа байх. Гэвч яг үүнээс шалтгаалаад бид зөрчил маргааныг даван туулах, бууруулах тодорхой механизмгүй байгаад асуудлын гол зангилаа оршиж байна. Үүнээс улбаалаад мөн орон нутгийн сөргөлдөөнийг хянах боломжгүй байдал үүсч, улмаар асар их хэмжээний хохирол үүсэх эрсдэл оршсоор байна. Иймд зарчмын хувьд бүх талууд хоёр талт ашиг сонирхлын зөрчлийг даван туулах тодорхой механизмыг бий болгох сонирхолтой байх учиртай.

АСЕМ нь ирээдүйд эдгээр асуудлыг нарийвчлан авч хэлэлцэх талбарыг бий болгож болох юм. АСЕМ-ын институтчилэлийг гүнзгийрүүлбэл яасан юм гэсэн асуулт европчууд бидний хувьд Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Бага Хурал, өнөөгийн Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ) болсон туршлагыг эргэн санахад хүргэж байна. АСЕМ-ыг яваандаа үүнтэй ижил төстэйгээр хөгжүүлэх боломж бий эсэхийг бид тунгаах хэрэгтэй.

Дээрх санаануудаар миний бие илтгэлээ төгсгөж, анхаарал хандуулсанд тань талархал илэрхийлье.

Манфред Грунд

ХБНГУ-ын Бундестагийн гишүүн бөгөөд Бундестаг дахь ХАХ/ХСХ Намын бүлгийн дарга

АСЕМ-ЫН ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТЫН СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Аливаа орны гадаад бодлого, олон улсын харилцааны үйл хэрэг ихэнхдээ тухайн орны ирээдүйн сайн сайхан, хөгжил дэвшил, амар амгалан байдлыг хангахад чиглэх тул эдийн засаг, санхүүгийн хэмжүүрээр тэр бүр илэрхийлэх аргагүй.

2014 оны 10 дугаар сард Италийн Милан хотноо зохион байгуулагдсан АСЕМ-ын дээд хэмжээний 10 дахь удаагийн уулзалтад оролцсон Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж дараагийн буюу 2016 онд болох дээд хэмжээний уулзалтыг эх орондоо зохион байгуулах болсон тухайгаа ард түмэндээ мэдэгдсэн билээ. Тэр цагаас хойш зөвхөн олон улсын харилцаа, гадаад бодлогын мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдын хүрээнд яригддаг байсан АСЕМ-ын талаар олон нийт сонирхож эхэлсэн юм. Энэхүү олон улсын томоохон арга хэмжээг зохион байгуулах болсонд иргэдийн ихэнх нь талархалтай хандаж байгаа ч зарим нэг шүүмжлэл гарч байгаа нь ихэвчлэн эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй холбоотой байна. Аливаа орны гадаад бодлого, олон улсын харилцааны үйл хэрэг ихэнхдээ тухайн орны ирээдүйн сайн сайхан, хөгжил дэвшил, амар амгалан байдлыг хангахад чиглэх тул эдийн засаг, санхүүгийн хэмжүүрээр тэр бүр илэрхийлэх аргагүй. Гэсэн хэдий ч энэ талаар зохих хэмжээнд мэдээлэл түгээх, тайлбарлан таниулж, эргэлзээг арилгах нь уг уулзалтыг амжилттай зохион байгуулах үндэс болно. Иймээс уулзалтыг зохион байгуулах ач холбогдлын талаар санал бодлоо нэмэрлэж буй нь энэ юм.



Энд “стратеги” хэмээх нэр томъёог цэрэг дайны, аюулгүй байдлын уламжлалт, явцуу утгаар нь бус, харин хэтийн зорилгодоо хүрэхийн тулд урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий чиглэл хэмээх өргөн утгаар нь хэрэглэж байна.

АСЕМ болон 11 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтын онцлог

Хүйтэн дайн дууссанаар улс орнуудын харилцааны шинэ үе эхэлж, эдийн засгийн харилцаа, “зөөлөн хүчний” ач холбогдол өссөн нь АСЕМ үүсэх хөрс болсон юм. Ялангуяа дэлхийн эдийн засаг, хөгжилд Азийн орнууд, тухайлбал, БНХАУ болон Зүүн, Зүүн Өмнөд Азийн орнууд далайцтай нөлөө үзүүлэх болсон нь яриа хэлэлцээний энэ механизм бүрэлдэн тогтох, бэхжихэд түлхэц болсон байна. Европ, Азийг дамнан зангидаж чадсан улс, гүрэн дэлхий дахиныг бүхэлд нь эрхшээх тухай өнгөрсөн зууны эхэн үеийн үзэл санаа байдаг ч энэ удаад хэн нэгний давамгайлал, хүчин дор бус, харин хоёр тивийн улс орнууд ижил тэгш

эрхийн зарчмаар, харилцан ашигтай хамтын ажиллагааны талаар яриа хэлэлцээ явуулж байгаа нь олон талт харилцаа (multilateralism), бүс нутаг хоорондын хамтын ажиллагаа (interregionalism)- ны хэлбэр юм. Даяаршлын үр дүнд “дэлхий жижигрч”, учирч буй бэрхшээл адил болж байгаа тул түүнийг давах, шийдвэрлэхэд хамтын тогтолцооны ач холбогдол өсөн нэмэгдэж байна.

АСЕМ өнөөдрийн байдлаар 51 улс, 2 олон улсын байгууллагыг хамарч байна. Дэлхийн нийт хүн амын 62,3 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 57 хувь АСЕМ-ын орнуудад ноогдох бөгөөд өндөр хөгжилтэй Их-20 орны 12 нь АСЕМ-д багтаж байгаа юм. АСЕМ нь засгийн газар хоорондын байгууллага биш, (үүгээрээ ЕХ, НҮБ зэрэг олон улсын байгууллагаас ялгаатай), үйл ажиллагааг нь зохицуулан зохион байгуулах байнгын тогтолцоо, нарийн бичг дарга нарын газар зэрэг бүтэцгүй (үүгээрээ АПЕК-с ялгаатай). Харин хоёр тивийн улс орнууд улс төр, эдийн засаг, нийгэм- соёлын асуудлаар албан бус яриа хэлэлцээ явуулдаг тогтолцоо юм. АСЕМ тодорхой нэг асуудлыг барьж шийдвэрлэдэггүй, билгэ тэмдгийн чанартай гэсэн түгээмэл шүүмжлэл байдаг. Гэвч, улс орнуудын нөхцөл байдал, харилцаа холбоо ихээхэн өөрчлөгдсөн өнөө цагт хоёр том тивийн үнэт зүйл, улс төрийн тогтолцоо, соёл иргэншлээрээ ялгаатай улс орнууд нэг дор чуулж “хатуу шийдэлд хүрэхгүй ч асуудлаа ярилцдаг, ний нуугүй үгээ хэлж ойлголцдог ийм индэр”байх нь ихээхэн чухал юм.

2016 онд манай улсад болох АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт дараах онцлогтой байна:

- АСЕМ үүсч байх үеийн нэг туйлт тогтолцоо өөрчлөгдөж олон жилийн турш өрнөдийн давамгайлалд явж ирсэн эдийн засаг, санхүүгийн тогтолцоонд сорилт учраад байна. Жишээлбэл, Хятадын санаачилсан Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк зэрэг санаачилгад Европын орнууд нэгдсэн байр суурьгүй ч дараалан нэгдсээр байна.
- Олон улсын харилцаа ээдрээтэй болж, Европ, Ази тивд, түүний дотор АСЕМ-ын орнуудыг хамарсан зөрчил, хямрал үүсэж, цаашид шинээр гарч болзошгүй нөхцөл бүрдэж байна. Тухайлбал, Украины хямрал, түүнээс үүдсэн Орос, Европын зөрчил, түүнчлэн Зүүн Өмнөд Азийн газар нутгийн маргаан, Европ руу чиглэсэн дүрвэгчдийн урсгал, террорист халдлага зэргийг дурдаж болно.
- АСЕМ өөрөө гурав дахь аравныхаа гараан дээр ирээд байгаа бөгөөд туулсан замаа эргэн харж, ирээдүйд чиглэсэн зарим өөрчлөлт хийх эсэх талаар яригдаж байна. Албан бус яриа хэлэлцээнээс асуудал хөндөж, барьцтай шийдвэр гаргадаг болох эсэх, гишүүнчлэлийн талаар тодруулах, хэлэлцдэг сэдвийн хүрээг илүү нарийн болгох, үйл ажиллагааг хөтлөн чиглүүлдэг байнгын бүтэц (secretariat)-тэй болох эсэх талаар шийдвэрлэх зэрэг сорилтын өмнө ирээд байна.

Монгол улс дээрх онцлогуудыг харгалзан үзэж, “Ази, Европын “хатуу” болон “зөөлөн” харилцаа холбоог өргөжүүлэх, улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хамтын ажиллагааг дэмжихэд чухал ач холбогдол өгч, өөрийн хувь нэмрийг оруулахын төлөө” ажиллах юм. Түүнчлэн зохион байгуулалт төдийгүй хэлэлцэх асуудлын агуулгад анхаарал хандуулж, тус механизмын цаашдын хандлагыг тодорхойлоход нь санаачилгатай ажиллах шаардлагатай байгаа юм.

Дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулахын ач холбогдол

Дээр дурдсанчлан олон улсын харилцааны үйл явдал, санаачилгын үр дүн тэр бүр шууд гарахгүй, ач холбогдол нь

*Даяаршлын үр дүнд
“дэлхий жижгирч”,
учирч буй бэрхшээл
адил болж байгаа тул
түүнийг давах,
шийдвэрлэхэд хамтын
тогтолцооны ач
холбогдол өсөн
нэмэгдэж байна.*

*Олон улсын харилцаа
ээдрээтэй болж, Европ,
Ази тивд, түүний дотор
АСЕМ-ын орнуудыг
хамарсан зөрчил,
хямрал үүсэж, цаашид
шинээр гарч болзошгүй
нөхцөл бүрдэж байна.*

**Ялангуяа манайх шиг
газар зүйн түгжигдмэл
байрлалтай оронд
идэвхтэй байх нь оршин
тогтноход шууд
нөлөөтэй.**

**АСЕМ-аар "Гуравдагч
хөрш"-ийн бодлого
бодит агуулгаар
баяжина.**

алсдаа тодрох нь түгээмэл байдаг. Гэсэн хэдий ч мэргэжилтэн, судлаачдын илэрхийлсэн санал бодол, өөрийн дүгнэлтийг нэгтгэн тус үйл ажиллагааны дам ач холбогдлыг илэрхийлэх оролдлого хийв. Дам хэмээсний учир нь, цуврал хурлуудын үеэр ирэх зочдын урсгалаас орох орлого, бүтээн байгуулалт зэрэг шууд, материаллаг давуу талыг дурдаагүй болно.

• Олон улсын тавцанд Монгол улсын нэр хүнд өснө: Сүүлийн жилүүдэд манай улс олон улсын харилцаанд идэвхтэй байр суурь баримтлах болсноор "хэрэглэгчээс тоглогчийн" байр сууринд шилжсэн билээ. Жижиг орны хувьд хувьсал, хөгжлийн эргүүлэгт татагдах бус, өөрийн хэмжээнд зам мөрөө гарган идэвхтэй байх нь чухал. Ялангуяа манайх шиг газар зүйн түгжигдмэл байрлалтай оронд идэвхтэй байх нь оршин тогтноход шууд нөлөөтэй. Ийнхүү олон улсын тавцанд нэр хүндээ өсгөх, байр сууриа дээшлүүлэх боломж буйг Ерөнхийлөгч "манай улсын жин нэмэгдэнэ" хэмээн оновчтой илэрхийлсэн.

• Гадаадын улс орнуудад эх орноо сурталчилна: Дээд хэмжээний уулзалт болон бусад цуврал арга хэмжээнд нийт 800 орчим сэтгүүлч ажиллана гэсэн урьдчилсан тооцоо гарчээ. Эдгээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудаар дамжуулан Монгол Улсыг сурталчлах өргөн боломж нээгдэнэ. Энэ нь байгал, аж амьдрал, соёл урлаг төдийгүй улс орны хөгжил, нийгэм улс төрийн тогтолцоог гадаад орнуудад таниулах алхам болно. Ийнхүү танигдсан улс хожим хамтын ажиллагаа хөгжүүлэхэд дөхөмтэй. Нөгөө талаас ийнхүү танигдсан улсад учирч буй сорилт, бэрхшээлийг бусад улс орон хуваалцахад, дэмжихэд бэлэн байх болно.

• Монгол Улс дэлхийн тавцанд үүрэг, хариуцлага хүлээхүйц хэмжээнд хүрсний илэрхийлэл болж итгэл хүлээнэ. Өмнө нь манай улс 2003 онд Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын сайд нарын бага хурал, 2013 онд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн бага хурал, 2015 онд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн чуулган зэрэг томоохон арга хэмжээг зохион байгуулсан билээ. Ирэх онд болох АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт эдгээртэй харьцуулбал цар хүрээ, оролцогчдын зиндааны хувьд ахиж байгаа нь манай улс алхам алхмаар олон улсад итгэл олж буйн илэрхийлэл юм.

• Худалдаа, хөрөнгө оруулалтын түншлэл, холбоо тогтооно: АСЕМ-ын хамрах хүрээнд эдийн засгийн асуудал улс төрийн дараа хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байдаг нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгдийн илэрхийлэл. Дээд хэмжээний уулзалтаас гадна Европ-Азийн бизнесийн чуулган болж улс орнуудын шилдэг, манлайлагч бизнесмэнүүд, томоохон компаниудын төлөөлөл ирдэг. Энэ үеэр монголын бизнесмэнүүдэд харилцаа холбоо тогтоох боломж бий. Үүнийг ашиглан сүүлийн 2 жилд эрс буурсан гадаадын хөрөнгө оруулалтыг дахин нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх алхмуудыг төлөвлөх шаардлагатай.

• Олон улсын харилцаа, гадаад бодлогын салбарт хүний нөөцийг бэхжүүлж, чадавхжуулна: Жижиг орны хувьд олон улсын байгууллага, институциудад өөрийн боловсон хүчнээ багтаан ажиллуулах, дадлаг туршлага эзэмшүүлэх нь чухал. Энэ үүднээс олон улсын харилцаа, хамтын ажиллагааны чиглэлд хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулахад нэмэр болно. Дээд хэмжээний уулзалт, бусад хуралд зохион байгуулагч, хурал удирдагч, орчуулагч бэлтгэх нь цаашид бусад үйл ажиллагаа

зохион байгуулах, олон улсын байгууллагад орж ажиллах суурь болох юм.

- АСЕМ-аар “Гуравдагч хөрш”-ийн бодлого бодит агуулгаар баяжина. Хоёр их гүрний дунд байрлалтай манай орны онцлогоос үүдэн “гуравдагч хөрш”-ийн бодлого гарсан бөгөөд уг бодлого амжилттай хэрэгжих үндэс нь хоёр хөрштэйгөө сайн харилцаатай байх, түүнчлэн хөрш болон “гуравдагч хөршүүд” сайн харилцаатай байх явдал юм. Ялангуяа хоёр хөрш, гуравдагч хөршийн аль алины төлөөлөлтэй байгууллага, механизмд орох нь уг бодлогыг хэрэгжүүлэхэд хялбар бөгөөд үр дүнтэй болох нь ЕАБХАБ-ын жишээнээс харагдсан билээ. АСЕМ ч үүний адил хоёр хөрш, Япон, Өмнөд Солонгос болон Европын “гуравдагч хөршүүдийг” хамтатган яриа хэлэлцээ өрнүүлэх таатай талбар болох юм.

- АСЕМ хоёр тивийг холбосон эдийн засаг, дэд бүтцийн төслүүдэд оролцоход түлхэц үзүүлнэ. Сүүлийн жилүүдэд ОХУ Ази тив дэх эдийн засгийн бодлогодоо ихээхэн анхаарал хандуулах боллоо. Ялангуяа Сибирийн байгалийн баялагт тулгуурлан, Алс Дорнодын бүс нутгаараа дамжин Азийн эдийн засгийн өсөлтийн үр шимээс хүртэхийг эрмэлзэж байна. Яг үүнтэй зэрэгцэн урд хөрш БНХАУ эдийн засгийн “багтаж ядсан” үлэмж нөөцөө зохистой зарцуулах замаар Төв Азиар дамжин Европын зах зээлд нөлөөгөө тогтоохыг хүсэж, “Шинэ торгоны зам” зэрэг санаачилга гаргаж байна. Европоос Ази руу чиглэсэн Оросын сонирхол, Азиас Европыг чиглэсэн Хятадын сонирхлын уулзвар дээр байрлалтайн хувьд бид эдийн засаг, тээвэр, дэд бүтцийн төслүүдийн зангилаа болох боломжтой. Гэвч одоогоор дээрх хоёр урсгал биднээс “хөндий өнгөрөх” хандлагатай байна. Иймд зөвхөн газар зүйн хувьд төв байршилтай төдийгүй улс төр, дипломат, хамтын ажиллагааны таатай орчин болохоо харуулж, хоёр хөршийг “гуравдагч хөрш”-үүдээр “ятгуулах” боломж байна.

- Газар зүйн байрлал, хөгжлийн чиг хандлагын хоёрдмол байдлыг багасгах

Монгол Улс газарзүйн хувьд Төв Азийн орон боловч эдийн засаг, нийгмийн хөгжлийн баримжааг дорно зүгт хандуулж, Зүүн Хойд Ази, Зүүн Азийн эдийн засгийн интеграцид нэгдэн, тус бүс нутгийн эдийн засгийн эрчимтэй өсөлтийн хүрээнд багтахыг эрмэлзэж ирсэн нь зөв сонголт. Гэвч үүнээс үүдэн Төв Азийн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа суларч, хоцрох эрсдэл бий. Хоёр тивийг холбосон хамтын ажиллагаа, зөвлөлдөөний механизмд идэвхтэй оролцон, холбох үүрэг гүйцэтгэснээр энэхүү хоёрдмол, “хэлбийсэн” байдлыг багасгаж, Төв Азийн бүс нутгийн ирээдүйн хөгжлийн тойргийн гадна үлдэх эрсдэлийг багасгах юм.

- Цаашид олон улсын байгууллагын төв болох алхам хийгдэнэ. Монгол Улс зөвхөн Европ, Азийн дунд, өрнө дорнын иргэншлийн зааг дээр оршдог төдийгүй дэлхийн бусад бүс нутаг, томоохон төвүүдийн уулзварт оршдог. Тухайлбал, Монгол Улс агаарын тээврийн “алтан” байрлалтай бөгөөд үүнийгээ ашиглан “хааб” байгуулж дэлхийн улсуудыг транзит тээвээр холбох тухай судалгаа, судлаачийн дэвшүүлсэн санаа бий. Олон улсын сурал, чуулганыг зохион байгуулах, цаашид тогтмолжуулан туршлага хуримтлуулж, ирээдүйд дэлхий нийтийг хамарсан олон улсын байгууллагын салбар, төвүүдийг байршуулж чадвал эдийн засгийн ач холбогдолтой төдийгүй аюулгүй байдал, тусгаар тогтнолоо бататгасан алхам болно. Энэ стратегийг амжилттай хэрэгжүүлж буй Швейцарь, Австри улсуудын жишээ байна.

**АСЕМ хоёр тивийг
холбосон эдийн засаг,
дэд бүтцийн төслүүдэд
оролцоход түлхэц
үзүүлнэ.**

**Монгол Улс газарзүйн
хувьд Төв Азийн орон
боловч эдийн засаг,
нийгмийн хөгжлийн
баримжааг дорно зүгт
хандуулж, Зүүн Хойд
Ази, Зүүн Азийн эдийн
засгийн интеграцид
нэгдэн, тус бүс нутгийн
эдийн засгийн эрчимтэй
өсөлтийн хүрээнд
багтахыг эрмэлзэж
ирсэн нь зөв сонголт.**

**Энэ удаагийн
уулзалтаар тус
механизмын цаашдын
хөгжлийн шинэ шат
тавигдана гэсэн хүлээлт
оролцогч улсуудын дунд
байна.**

**АСЕМ-ын Дээд
хэмжээний чуулган,
дагалдах хурал,
уулзалтуудын зохион
байгуулах нь ойрын
хугацаанд эдийн
засгийн хувьд дарамт
болох ч алсдаа ач
холбогдол нь өндөр
байна.**

Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн Байнга төвийг сахих тухай санаачилга ч үүний суурь болж өгнө.

Дүгнэлт

Олон улсын харилцаа, эдийн засаг, аюулгүй байдлын чиг хандлага тодорхойгүй байгаа үед АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт манай оронд зохион байгуулагдах гэж байна. Хоёр тивийн аль алинд улс төр, эдийн засаг, нийгмийн багагүй сорилтууд тулгарч, яриа хэлэлцээ явуулах шаардлага, хэрэгцээ их байгаа нь энэхүү механизмын ач холбогдлыг улам тодруулж байгаа юм. Түүнчлэн улс төр-аюулгүй байдлын асуудлууд, эдийн засаг- дэд бүтцийн санаачилгууд яриа хэлэлцээний гол сэдэв байх магадлалтай.

Энэ удаагийн уулзалтаар тус механизмын цаашдын хөгжлийн шинэ шат тавигдана гэсэн хүлээлт оролцогч улсуудын дунд байна. Тухайлбал, гишүүнчлэл, бүтэц, хамрах асуудлын хүрээ, хэлэлцсэн зүйлийг бодитоор хэрэгжүүлэх арга зам, хүлээх үүргийн талаар хөндөгдөнө. Ихэнх оролцогч энэхүү механизмыг ойрын үед ямар нэг үүрэг хариуцлага үүрүүлдэггүй, яриа хэлэлцээний талбар хэвээр байлгах тал дээр байна. Гэсэн хэдий ч өнгөрсөн хугацаанд явж ирсэн арга барилыг өөрчлөх, ахиц гаргах хэрэгтэй гэсэн хүлээлт бас байна. Дээд хэмжээний уулзалтаас гарах “Улаанбаатарын тунхаглал” энэ бүхэнд тодорхой хариулт болох ёстой.

Манай улс энэхүү үйл явдлаар дамжуулан хоёр тивийг холбосон улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцогч, зуулчлагч, дамжуулагч болох боломжийг эрэлхийлэх хэрэгтэй. Ялангуяа “Улаанбаатарын тунхаглал”-ыг цаашдын үйл ажиллагааны нэршил болгон, хоёр болон олон талт хамтын ажиллагааны бусад бодлого, санаачилгатайгаа холбох, уялдуулах боломж байна.

АСЕМ-ын Дээд хэмжээний чуулган, дагалдах хурал, уулзалтуудын зохион байгуулах нь ойрын хугацаанд эдийн засгийн хувьд дарамт болох ч алсдаа ач холбогдол нь өндөр байна. Нөгөө талаас, уулзалттай холбогдсон бүтээн байгуулалтуудыг цаашид хэрхэн ашиглахаа зөв төлөвлөж чадвал одоогийн зогсонги эдийн засагт бага боловч хөдөлгөөн оруулж, эргэлт үүсгэнэ. Ойрын хугацаанд АСЕМ-ын талаар, Дээд хэмжээний уулзалтын ач холбогдлын талаар дотооддоо олон нийтэд хандан зохистой ойлголт, мэдээлэл өгч, сурталчлах нь уг үйл ажиллагааг амжилттай зохион байгуулахад түлхэц болно.

Др. Доржраагийн Мөнхтөр

**Монгол улсын Стратеги Судлалын Хүрээлэнгийн Европ,
Хойд Америк судлалын төвийн эрхлэгч**

Ашигласан материал:

- АСЕМ-ын 11 дэх удаагийн дээд хэмжээний уулзалтад зориулсан цахим хуудас: www.asem11.mn
- АСЕМ-ын албан ёсны цахим хуудас: <http://www.asem11.mn/>
- "Төр ганцаар хийж чадахгүй". Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, Гадаад бодлогын зөвлөх Л.Пүрэвсүрэнгийн ярилцлага. 2014 оны 10 дугаар сарын 24. <http://politics.news.mn/content/193053.shtml>
- "Гадаад бодлого дээр Монголын жинг нэмэх бодлогын нэг ялалт". Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Д.Баярхүүтэй хийсэн ярилцлага. 2014 оны 10 сарын 21. <http://politics.news.mn/content/192711.shtml>
- АСЕМ-ын Бэлтгэл ажлын албаны дарга, Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд Д.Ганхуягийн ярилцлага. 2015 оны 5 сарын. <http://www.asem11.mn/news/9.shtml>
- "АСЕМ-ын хурлууд Монголын мэдэлд ирлээ". Сэтгүүлч Э.Энэрэл. 2015 оны 11 сарын 13. <http://enerel.niitlech.mn/content/7420.shtml>
- Christopher M. Dent: *The Asia-Europe Meeting and Inter-Regionalism*. <http://www.jstor.org/stable/10.1525/as.2004.44.2.213?origin=JSTOR-pdf>
- *Bangkok Initiatives on the Future Direction of ASEM*. http://www.eucentre.sg/wp-content/uploads/2015/04/Bangkok-Initiatives-on-the-Future-Direction-of-ASEM_final.pdf
- Yeo Lay Hwee. *ASEM: Looking back, looking forward*. 2000. <http://www.jstor.org/stable/25798481>
- *The Future of the Asia- Europe Meeting. Looking ahead into ASEM's third decade*. http://eeas.europa.eu/asem/docs/20150915-final-future-of-the-asem_website_en.pdf
- *Working together for a sustainable and secure Future: 12th ASEM Foreign Ministers' Meeting*. 06 November 16, 2015. http://eeas.europa.eu/statements-eeas/2015/151106_02_en.htm
- Dent, Christopher: *The Asia-Europe Meeting and Inter-Regionalism - Towards a Theory of Multilateral Utility*. In: *Asian Survey*, Vol. 44, No. 2, S. 213-236, 2004.
- Э.Энэрэл: АСЕМ-ын хурлууд Монголын мэдэлд ирлээ. Өдрийн сонин. 2015 оны 11 сарын 13-ны дугаар.

АСЕМ-ЫН ДЭЭД ТҮВШНИЙ 11 ДҮГЭЭР УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ЯВЦ

2014 оны 10 дугаар сард Милан хотноо болсон Ази-Европын харилцаа, хамтын ажиллагааг бататган хөгжүүлэх зорилго бүхий АСЕМ-ын уулзалтаас дээд түвшний 11 дүгээр уулзалтыг Монгол Улсад зохион байгуулахаар шийдвэрлэсэн билээ.



**Дээд хэмжээний
уулзалтаар Монгол
орноо дэлхий нийтэд
таниулан харуулах улс
төр, эдийн засаг, нийгэм
соёлын олон талын ач
холбогдол бүхий хосгүй
боломж гэдгийг нэмж
тайлбарлах нь илүүц
биз ээ.**

Ази, Европын болон Авсрали, Шинэ Зеланд зэрэг 51 орон, олон улсын 2 байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн олон улсын яриа хэлцээний шинэлэг, өвөрмөц талбар АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтыг улс орондоо амжилттай зохион байгуулах нь монголчууд бидний хувьд нэр төр, өндөр хариуцлага. Дээд хэмжээний уулзалтаар Монгол орноо дэлхий нийтэд таниулан харуулах улс төр, эдийн засаг, нийгэм соёлын олон талын ач холбогдол бүхий хосгүй боломж гэдгийг нэмж тайлбарлах нь илүүц бизээ.

Энэхүү уулзалт нь аугаа их түүх, байгалийн баялагаараа дэлхийн танил Монгол улс ардчилал, чөлөөт зах зээлийн замаар замнасан 25 жилийнхээ хөгжил, туршлагыг дэлхий нийтэд дэлгэн таниулж, хөрөнгө оруулагчид, жуулчид, урлаг соёлынхоны хүрэх цэг, зорих газар болгон таниулахад давхар боломж олгож байгаараа онцлог гэж хэлж болно.

Энэ хосгүй боломжийг дан ганц Монгол улсын төр засаг бус, хувийн хэвшил, ард олноороо нийт монголчууд бид бүхэн хэрхэн ололт болгож, Ази-Европын харилцаа холбоонд өөрийн гэсэн бодит хувь нэмрээ оруулах талаар өндөр хариуцлагатай ажиллах шаардлагатай байна.

АСЕМ-ын яриа хэлцээг Ази, Европын төр, засгийн газрууд ерөнхийлөн чиглүүлдэг бол хувийн хэвшил, иргэний нийгэм, оюутан залуучууд, эрдэмтэн судлаачид, парламентийн гишүүд, сэтгүүлчид зэрэг нийгмийн салбарынхан идэвхийлэн оролцдог. Үүнтэй уялдуулан манай улсад ирэх жил дээд түвшний уулзалтаас гадна АСЕМ-ын хүрээний хэд хэдэн дагалдах арга хэмжээ, уулзалтууд зохион байгуулагдана.

Энэ дашрамд АСЕМ-ын уулзалтыг эх орондоо зохион байгуулах санаачилгыг дэмжиж хамтран ажиллаж буй хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, нийт ард иргэддээ гүн талархал илэрхийлье. Мөн дээд түвшний уулзалтын бэлтгэл хангахад дэмжлэг туслалцаа үзүүлж буй АСЕМ-ын орнуудад талархлаа илэрхийлье.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 163 тоот зарлигаар АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулах, чиг үүрэг бүхий Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний Зөвлөлийг байгуулсан билээ. Өнгөрсөн хугацаанд Үндэсний Зөвлөл 11 удаа хуралдаж дээд түвшний уулзалтын бэлтгэлийг хангахтай холбоотой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэж ирлээ.

Улс орны өнөөгийн эдийн засгийн байдалтай холбогдуулан бэлтгэл ажлын асуудлуудыг аль болох улсын төсөвт дарамт багатайгаар, дотоод боломждоо тулгуурлан, төр хувийн хэвшлийн түншлэл, АСЕМ-ын гишүүн орнуудын сайн санааны тусламж, дэмжлэгт тулгуурлан шийдвэрлэх зарчмаар ажиллаж байна. Уулзалтын бэлтгэл ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн тул хийж гүйцэтгэсэн гол ажлуудаас тоймлон танилцуулъя.

Дээд түвшний уулзалтаар хэлэлцэх асуудлууд болон баримт бичгүүд

Дээд түвшний уулзалтыг зохион байгуулах орны хувьд уулзалтаар хэлэлцэх асуудлуудыг тодорхойлох, баримт бичгүүдийн төслийг боловсруулахад манай улс голлох үүрэгтэй. Энэ хүрээнд АСЕМ-ын хүрээний уулзалт, арга хэмжээнүүдэд манай улс идэвхтэй оролцох чиглэл баримталж ирлээ.

Ирэх оны дээд түвшний уулзалтаар Ази, Европын болоод дэлхий нийт, бүс нутгийн тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж “Даргын мэдэгдэл” хэмээх баримт бичиг гаргана. 2016 онд АСЕМ-ын 20 жилийн ой тохиож байгаа бөгөөд АСЕМ-ын өнгөрсөн 20 жилийг дүгнэж, ойрын ирээдүйг тодорхойлох “Улаанбаатарын тунхаглал” хэмээх баримт бичгийг боловсруулан гаргах юм.

Манай улс АСЕМ-ын 20 жилийг тэмдэглэх Ажлын хэсгийг даргалагч орны хувьд саяхан Люксембургт болсон АСЕМ-ын Гадаад Хэргийн сайд нарын уулзалтын үеэр 20 жилийн баярыг тэмдэглэх үйл ажиллагааг албан ёсоор нээж, Монголын соёл урлагийн үзүүлбэрийг зохион байгуулсан болно.

Дээд түвшний уулзалтаар хэлэлцэх асуудлуудын судлагаа, шийдвэрлэх боломжит гарцын талаар гадна, дотны эрдэмтэд, судлаачдын дэмжлэгтэйгээр бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

АСЕМ-ын асуудлуудыг албан бусаар хэлэлцдэг ганцаарчилсан уулзалтын retreat хэлбэрийг АСЕМ-ын гишүүн орнуудын дийлэнхийн саналын дагуу цаашид ч бататган хэрэгжүүлж уулзалтуудыг тодорхой үр дүнд хүргэхийг эрмэлзэх болно. Дээд түвшний уулзалтын товын талаар гишүүн орнуудтай тохироод байна.

Уулзалтын байр болон зочид буудал

АСЕМ-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалтыг 2016 оны 7 дугаар сарын 15-16 өдрүүдэд “Шанри-Ла” зочид буудалд хийхээр Үндэсний Зөвлөлөөс шийдвэрлэсэн болно. Өнөөгийн байдлаар олон улсын өндөр дээд хэмжээний хурал зохион байгуулах хамгийн тохиромжтой газар нь энэ буудлын хурлын танхим байгаа болно.

Улаанбаатар хотын 100 гаруй зочид буудлуудаас үйлчилгээ, үйл ажиллагаа нь жигдэрсэн, зохион байгуулалтын түвшин, өндөр дээд хэмжээний зочид хүлээн авч байсан туршлага, олон улсын сүлжээний менежмент зэргийг харгалзан 44 зочид буудлыг АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтын зочид, төлөөлөгчдийг байрлуулахаар сонгоод 2015 оны 10 дугаар

Дээд түвшний уулзалтыг зохион байгуулах орны хувьд уулзалтаар хэлэлцэх асуудлуудыг тодорхойлох, баримт бичгүүдийн төслийг боловсруулахад манай улс голлох үүрэгтэй.

сарын 9-ний өдөр хамтран ажиллах Итгэмжлэл гардуулаад байна.

Түнш зочид буудлуудад шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгаа хийж, Үндэсний Зөвлөлөөр хэлэлцүүлэн, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулж зочид буудлуудад 150 тэрбум төгрөгийн зээл олгохтой холбогдуулан зээлийн санхүүжилтийг шийдэх тухай Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолын дагуу ажиллаж байна. Сонгогдсон зочид буудлуудад олгох хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлэх, хяналт тавих журам батлагдсан болно. Өнөөгийн байдлаар санхүүжилтийн асуудал эцэслэн шийдэгдээгүй байна.

Дээд түвшний уулзалтад оролцох АСЕМ-ын түнш орнуудын төр, засгийн тэргүүн нарыг байрлуулах “АСЕМ Вилла” цогцолбор хотхоны төслийг хэрэгжүүлэхэд олгох хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт шаардагдах 125 тэрбум төгрөгийг төслийн орлогоос эргэн төлөх нөхцөлтэйгөөр арилжааны банкаар дамжуулан санхүүжүүлэх тухай Монгол улсын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны 331 дугаар тогтоолын дагуу ажиллаж байна. Энэхүү төслийн санхүүжилтийн 40 хувь шийдэгдсэн.

Аюулгүй байдал, ёслол, улсын хил нэвтрэх асуудал

Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын албан хаагчдад зориулсан нэгдсэн сургалт зохион байгуулахад шаардагдах 374 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргах тухай асуудлыг Засгийн газрын 2015 оны 11-р сарын 2-ны өдрийн 427 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн.

Зэвсэгт хүчний жанжин штабаас Төрийн тусгай хамгаалалтын газарт 16 нэр төрлийн зэвсэг, галт хэрэглэл, дуран хараа, химийн болон тусгай хэрэгсэл, Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлд 11 төрлийн зэвсэг, галт хэрэглэл, химийн хэрэгсэл, ЗХЖШ, ХХЕГ-аас Төрийн тусгай хамгаалалтын газарт шилжүүлэх сум, галт хэрэгслийг түр шилжүүлэх тухай шийдвэр гаргаад байна.

Цагдаагийн тусгай тоноглол бүхий Toyota Prius 30 маркийн 52 ширхэг чиглүүлэгч автомашиныг 1,6 сая ам.долларын өртгөөр худалдан авах гэрээг “Иточу” компанитай байгуулсан боловч санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй хүлээгдэж байна.

Төлөөлөгчдийн үйлчилгээнд ашиглах бусад төрөл бүрийн оврын машинуудыг Ниссан Моторс компаниас нийлүүлэх талаар хэлэлцээ хийж байна. Түүнчлэн Солонгосын EXIM банкнаас авах том оврын автобуснуудыг АСЕМ-ын уулзалтуудын үеэр ашиглаж түүнээс хойш нийслэлийн нийтийн тээвэрт хэрэглэхээр тохиролцсон байгаа.

Төсвийн санхүүжилтээр АСЕМ-ын уулзалтад оролцох төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангахад зориулсан хуягласан автомашин худалдан авах урьдчилгаа төлбөрт шаардагдах эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаар Сангийн сайдад үүрэг өгөөд байна.

Шуурхай удирдлагын штаб байгуулахад шаардагдах зардлыг гадаадын техник тусламж болон хөнгөлөлттэй зээлийн хүрээнд шийдвэрлэхээр судалгаа хийн, бэлтгэн ажиллаж байна.

Зам тээвэр, харилцаа холбоо болон нисэх буудал

Иргэний нисэхийн ерөнхий газраас 21.7 тэрбум төгрөг өөрсдийн цэвэр ашгаас санхүүжүүлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Хөөрч буух зурвасын цемент бетон хучилтын 500 метрийн хүчитгэлийн ажлын гүйцэтгэл 100% хийгдэж дууссан. Агаарын хөлгийн 9 зогсоол шинээр барих ажил 100%- гүйцэтгэлтэй хийгдээд байна. Нийт 34 агаарын хөлгийг байршуулах хүчин чадалтай болсон. Чингис Хаан олон улсын нисэх буудалд транзит заал байгуулах ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

АСЕМ Виллагаас Шангри-Ла зочид буудал хүрэх замын хот тохижилт болон аюулгүй байдал болон “Чингис хаан” олон улсын нисэх буудлын бэлтгэл, “Чингис хаан” олон улсын нисэх буудлаас “Шангри Ла” зочид буудал хүрэх замын хот тохижилтын ажилтай танилцаж, зохих шийдвэрийг гарган, хэрэгжүүлэхээр ажиллаж байна. АСЕМ-ын дээд түвшний уулзалтын үеэр өндөр түвшний зочид төлөөлөгчид зорчих “Чингис Хаан” олон улсын нисэх буудлаас “АСЕМ Вилла” хүртэлх авто замын гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэх гэрээ байгууллаа.

“АСЕМ Вилла” хотхоны гаднах зам талбайн гэрэлтүүлгийн угсралтын ажил, Богд уулын арын авто зам, Баянзүрхийн товчооноос Яармагийн гүүрний урд уулзвар хүртэлх 17,1 км замын гэрэлтүүлэг угсралт, Яармагийн гүүрнээс “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал хүртэлх замын гэрэлтүүлэгчийг солих угсралтын ажлын төсөв болох 3,4 тэрбум төгрөгийн 1,5 тэрбум төгрөгийг АСЕМ-ын бэлтгэл ажлыг санхүүжүүлэх зардлаас, үлдсэн 1,9 тэрбум төгрөгийг 2016 оны Улаанбаатар хотын төсөвт суулгахаар шийдвэрлүүлээд байна.

Хэвлэл мэдээлэл болон сурталчилгаа

АСЕМ-ын дээд хэмжээний болон бусад уулзалтуудыг сурвалжлахаар гадаадын олон тооны хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагчид, төлөөлөгчид ирэх тооцоо байгаа. Дээд хэмжээний уулзалтын үеэр гадна, дотны хэвлэл, мэдээллийнхэнд зориулсан “Пресс центр” ажиллах бөгөөд гадаадын сэтгүүлчдийг хүлээн авах, мэдээллээр хангах, үйлчлэх ажлын бэлтгэлийг ханган ажиллаж байна.

АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтын албан ёсны логоны загвар зохион бүтээх уралдааныг нийт зураач, уран бүтээлчдийн дунд зарлан дүгнэж, шалгарсан логог АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтын албан ёсны цахим хуудас /asem11.mn/-ны хамт 2015 оны 5-р сарын 5-нд албан ёсоор зарлаж нээлтийг хийсэн.

Дээд түвшний уулзалтын талаарх мэдээ мэдээллийг хэвлэл мэдээлэл, олон нийтэд түгээх, уг уулзалттай холбоотой асуудлаар төр засаг, ард иргэдийг холбох гүүр болж ажиллах “Мэдээллийн төв”-ийг МОНЦАМЭ агентлагийн байранд нээхээр

төлөвлөн ажиллаж байна.

Бэлтгэл ажлын зардал, гадаадын тусламж дэмжлэг

Дээд түвшний уулзалтын бэлтгэл ажилд зориулж 2015 оны улсын төсөвт 5,0 тэрбум төгрөг үүнээс урсгал зардалд 2,5 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 2,5 тэрбум төгрөг төсөвлөгдсөн боловч улсын төсвийн өнөөгийн байдлын улмаас хөрөнгө оруулалтын санхүүжилт саатсан байгаа. Саяхан батлагдсан 2016 оны улсын төсөвт 21,0 тэрбум төгрөг төсөвлөсөн.

АСЕМ-ын гишүүн зарим орнуудаас дээд түвшний уулзалтыг зохион байгуулахад тухайлбал, Европын холбоо, БНХАУ, Япон, БНСУ, Швейцарь, Норвег, Ази-Европын Сангаас тодорхой тусламж, туслалцаа, зөвлөгөө үзүүлж байна. Дээрх тусламжийн хүрээнд харилцаа холбоо, аюулгүй байдал, нисэх буудал, хурлын байрны тоног төхөөрөмж, зочид буудлын тавилга, ёслолын хэрэгцээний зүйлс гэх мэт багтаж байгаа бөгөөд зочид буудлын менежмент, үйлчилгээний чиглэлээрхи сургалт голчлон орж байгаа болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Лувсанцэрэнгийн Оргил

Элчин сайд бөгөөд АСЕМ-ын Бэлтгэл Ажлын Албаны ахлах албан тушаалтан

БЕРЛИН ХОТНОО ЗОХИОГДСОН МОНГОЛ-ГЕРМАНЫ XIII ЧУУЛГАНЫ МОНГОЛЫН АЙЛЧЛАЛЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗУРГУУД



Монгол-Германы XIII Чуулганы Монголын айлчлалын бүрэлдэхүүн ХБНГУ-ын Христийн Ардчилсан Холбоо (ХАХ) Намын төв байрнаа

(зүүн гар талаас: Др. Даниел Шмюкинг (Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч), Цэрэндоржийн Ганхуяг (ИЗННамын Дарга), Проф. Пунсалмаагийн Очирбат (Монгол-Германы Чуулганы Тэргүүн бөгөөд Монгол Улсын анхны Ерөнхийлөгч), Ринчиннямын Амаржаргал (МУ-ын УИХ-ын Гишүүн), Лувсанвандангийн Болд (МУ-ын УИХ-ын Гишүүн), Лувсанцжамцын Удвал (Монгол-Германы Чуулганы Ерөнхий Нарийн бичгийн дарга) болон Батмөнхийн Дөлгөөн (Конрад-Аденауэр-Сангийн Хөтөлбөрийн менежер))



**ХБНГУ-ын Шинжлэх Ухаан ба Улс төрийн сангийн Азийн
судалгааны хэсгийн дарга Др. Ханнс Гюнтер Хилберттэй
хийсэн уулзалтын дараа**



ХБНГУ-ын Гадаад Хэргийн Яамны Монгол улсыг хариуцсан референт болон АСЕМ-ыг хариуцсан референтүүдтэй хийсэн уулзалт

Тюринген муж улсын Парламентын байранд зочлох үеэр
(Тюринген муж улсын Парламентын Ерөнхийлөгч Кристиан Кариусболон Тюринген мужийн Парламентын гишүүн Др. Марио Фоогтийн хамтаар)



ХБНГУ-ын Тюринген мужийн ХАХНамын төв байранд зочлох үеэр
(ХАХНамын Мужийн гүйцэтгэх дарга Хатагтай Эвелин Гроссын хамтаар)



**Монгол-Германы XIII Чуулганы оролцогчид
Конрад-Аденауэр-Сангийн Академийн байрнаа**



<http://www.kas.de/mongolei/>



Konrad
Adenauer
Stiftung



Монгол
Германы
Чуулган